



# Оюун Санааны Амьдралын Тухай Эргэцүүлэхүй

Рухи Институт



1-р дэвтэр



# Оюун Санааны Амьдралын Тухай Эргэцүүлэхүй

Рухи Институт

Энэ цуврал дах номууд:

Доор Рухи Институтээс боловсруулсан цуврал материалд өнөөгийн байдлаар буй номуудын нэрс байна. Уг номууд нь залуучууд болон насанд хүрэгсдийн нийгэмлэгтээ үйлчлэх чадавхыг хөгжүүлэх зорилго бүхий системтэй хүчин чармайлтын хүрэн дэх үндсэн шаталсан сургалтын материал болж байгаа юм. Рухи Институт мөн Бахайн хүүхдийн хичээлийн багшид зориулан энэхүү цувралын Гуравдугаар номоос салбарлан гарах багц сургалтын материал, мөн өсвөр насны бүлгийн удирдагчдыг бэлтгэхэд зориулж Тавдугаар номоос салбарласан багц материалыг тус тус боловсруулж байгаа билээ. Эдгээр багцыг мөн доор багтаав. Талбар дээр туршлага хуримтлагдан сайжрах хэрээр уг жагсаалт өөрчлөгдөж болох бөгөөд эдүгээ боловсруулалтын шатанд яваа сургалтын материалууд нийтэд хүртээлтэй болох түвшинд хүрсэн үед нь шинэ номууд нэмэгдэн орно гэдгийг дурдах нь зүй буй за.

1-р дэвтэр	<i>Оюун Санааны Амьдралын Тухай Эргэцүүлэхүй</i>
2-р дэвтэр	<i>Үйлчлэхээр Эгцлэн Босохуй</i>
3-р дэвтэр	<i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 1-р анги</i> <i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 2-р анги (салбар сургалт)</i> <i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 3-р анги (салбар сургалт)</i> <i>Хүүхдийн Хичээлийг Багшлахуй 4-р анги (салбар сургалт)</i>
4-р дэвтэр	<i>Ихэр Элч</i>
5-р дэвтэр	<i>Өсвөр Насны Залуучуудын Чадавхыг Нээн Хөгжүүлэхүй</i> <i>Анхны тэмүүлэл: Тавдугаар номын эхний салбар сургалт</i> <i>Өргөжин тэлж буй тойрог: Тавдугаар номын хоёр дахь салбар сургалт</i>
6-р дэвтэр	<i>Үйл Хэргийг Багшлахуй</i>
7-р дэвтэр	<i>Үйлчлэхүйн Зам Мөрөөр Хамтдаа Алхахуй</i>
8-р дэвтэр	<i>Бахауллагийн Гэрээс</i>
9-р дэвтэр	<i>Түүхийн ойлголттой болох нь</i>
10-р дэвтэр	<i>Эрч хүчтэй нийгэмлэгүүдийг бүтээн босгохуй</i>
11-р дэвтэр	<i>Материаллаг арга замууд</i>
12-р дэвтэр	<i>(боловсруулагдаж буй)</i>
13-р дэвтэр	<i>Нийгмийн үйл ажиллагаанд оролцохуй</i>
14-р дэвтэр	<i>(боловсруулагдаж буй)</i>

Copyright © 2016, 2020 Колумб улс дах Рухи Сан

Зохиогчийн бүх эрх хамгаалагдсан. Хэвлэлтийн хувилбар 4.1.3.PE нь 2020 онд хэвлэгдэв.

Originally published in Spanish as *Reflexiones sobre la vida del espíritu*

Copyright © 1987, 1995, 2008, 2020 by the Ruhi Foundation, Colombia

ISBN 978-958-59880-3-3

Ruhi Institute  
Cali, Colombia  
Email: [instituto@ruhi.org](mailto:instituto@ruhi.org)  
Website: [www.ruhi.org](http://www.ruhi.org)

Монголын Бахайчуудын ҮОСЧ  
+976 11 321867  
[secretariat@bahai.mn](mailto:secretariat@bahai.mn)  
[www.bahai.mn](http://www.bahai.mn)

## Агуулга

Сургагчид хандах хэдэн зүйл.....	v
Бахайн сургаал үгсийг ойлгон тунгаахуй. ....	1
Мөргөл.....	15
Амьдрал ба үхэл .....	31



## Сургагчид хандах хэдэн зүйл

Рухи Институтээс санал болгодог үндсэн шаталсан сургалтуудын эхний ном болох Оюун Санааны Амьдралын тухай Эргэцүүлэхүй номыг судалж буй нутаг орон, байршлуудын тоо дэлхий даяар олон жилийн туршид өссөөр ирлээ. Дийлэнх тохиолдолд, тогтмол уулздаг сургалтын дугуйлангаас бүрдсэн, эсвэл эрчимтэй судлах кампанит ажлын хүрээнд хамтдаа нийлсэн, эсвэл сургуулийн амралтын үеэр зуслан сургалтад цугларсан анд нараас бүрдсэн бүлэг анд нөхөд уг материалыг уншиж, судалдаг. Аль ч тохиолдолд байлаа гэсэн тухайн бүлгийн хэн нэг нь сургагчаар үйлчилнэ. Сургагч ба оролцогчид хоорондын харилцаа нь багш ба сурагч оюутан хоорондын харилцаатай огт адилгүй юм. Харин хүн бүр хамтдаа суралцахаар тэмүүлдэг энэхүү үйл явцад бүгд л өөрийн ухамсар хүслээрээ оролцдог билээ. Гэхдээ сургагч нь хэлэлцүүлгээс ангид идэвхгүй чиглүүлэгч төдийхөн бас байх ёсгүй юм. Сургагч нь ихэвчлэн энэхүү шаталсан сургалтын цуврал дахь нэлээд хэдэн номыг дүүргэж, уг сургалтаас санал болгодог үйлчилгээнүүдийг хийж гүйцэтгэсэн туршлагатай байх хэрэгтэй бөгөөд тэгснээрээ бүлгийнхээ гишүүн тус бүрд судалж буй материалынхаа зорилгыг ойлгож гүйцэлдүүлэхэд нь тусалж дэмжих чадвартай болсон байдаг. Нэгдүгээр номын сургагчаар үйлчлэх анд нөхдийн хувьд энэхүү удиртгал хэсэгт танилцуулсан санаануудыг үе үе эргэн харж судлах нь тун тустай байж болох билээ.

Дэлхий даяар институтийн эхний шатны энэхүү сургалтад янз бүрийн гарал үүсэлтэй хүмүүс хамрагддаг. Тэдний зарим нь хэдийнээ Бахайн нийгэмлэгийн гишүүн байх бөгөөд хүлээн авсан Үйл хэрэгтэй үйлчлэх чадавхаа хөгжүүлэхийг хүсэн сургалтад оролцдог бол нөгөө хэсэг нь Бахай Шүтлэгийг шашных нь хувьд судлах замналынх нь эхлэл хэмээн үздэг байна. Өөр нэг хэсэг нь Бахайн эрхэм дээд үзэл санаанд татагдаж, нийгэмлэгийн зорилго ба үйл ажиллагаатай танил дотно болох хүслээр оролцдог. Эцэст нь, Бахайн нийгэмлэгээс хэрэгжүүлж буй аль нэг хөтөлбөрөөр дамжуулан нийгэмд үйлчлэх өөрсдийн чадавхыг хөгжүүлэхийг хүссэндээ эхний алхам болгож уг сургалтад хамрагдаж байгаа залуучууд мөн байх бөгөөд тэдний тоо улам нэмэгдсээр байна.

Рухи Институтийн сургалтууд нь хүн төрөлхтөнд үйлчлэхүйн зам мөрийг тавьж өгдөг бөгөөд тэрхүү замаар өөр өөрийн хурдаар алхах явцдаа бид бусдадаа тусалж, бас тэднийхээ тус дэмийг хүртэж байдаг гэдэг нь оролцогч бүрд эхнээсээ тодорхой байх хэрэгтэй. Энэхүү зам мөрөөр алхах гэдэг нь өөрийн оюун санааны болон оюун ухааны өсөлт хөгжилтөд анхаарах, мөн нийгмийг өөрчлөн хувьсгах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах гэсэн ёс суртахууны хоёр талт зорилгын төлөө хичээн зүтгэнэ гэсэн утгыг агуулж байдаг. Уг замаар хөгжин дэвжих явцад ойлголт, мэдлэг, оюун санаалаг зан чанарууд, сайшаалтай зөв хандлагууд, мөн төрөл бүрийн ур чадвар зэргийг шаардах олон тооны чадвар чадавх хөгждөг. Институтийн номуудад ашиглагдаж буй мэдлэгийн үүсвэр нь нэг талаас Бахай Шүтлэгийн сургаалууд, нөгөө талаас материаллаг болон оюун санааны соёл иргэншлийг урагшлуулах үйлсэд дэлхийн Бахайн нийгэмлэгийн хуримтлуулж буй туршлага юм. Институт нь чухамдаа, хувь хүнийхээ хувьд бид ямар хүн болон хөгжих, ямар соёл иргэншлийг бүтээн босгох талаарх Бахауллагийн зөн хараанаас урам онгодыг авдаг билээ. Ямар гарал үүсэлтэйгээсээ үл хамааран оролцогчид бүгдээрээ ном бүрийн бүлэг бүрд тодорхой илэрхийлэгдсэн буй энэхүү зөн харааг нээлттэй хүлээн авна хэмээн найдаж байна.

Янз бүрийн номлол сургаал болон итгэл үнэмшлүүд нь итгэгч дагалдагчдаа олж авахын тулд юу ч хийхээс үл буцах болсон энэ ертөнцөд Шүтлэгийн талаар сайн мэдэхгүй зарим хүн Рухи Институтийн цаад зорилгын талаар “Намайг шашнаа соль гэж асууж байгаа юм уу?” эсвэл “Намайг ямар нэг шашинд элсэхийг хүсээд байна уу?” гэх зэрэг зүй ёсны асуултуудыг асууж магад. Иймэрхүү асуултууд нь үндсэн шаталсан сургалтуудын зорилгыг дээр тоймлосон маягаар тайлбарлах боломжийг сургагч нарт олгож байгаа юм. Мөн хэдийгээр Бахайчууд найз нөхдөө нийгэмлэгтээ нэгдэж орохыг нь зүй ёсоор хүсдэг ч гэлээ Бахайн сургаалд бусдыг хүчээр элсүүлэхийг хориглодог болохыг сургагч нэмж хэлж болох юм. Институтийн сургалтуудаар дамжин нээгддэг үйлчлэхүйн зам мөрөөр замнах явдал нь Бахауллагийн сургаалуудыг улам бүр гүн гүнзгий ойлгохыг шаарддаг агаад үүнийг ч Институтийн материалуудад тов тодорхой байлгахыг хичээдэг. Харин тэдгээрийг хүлээн зөвшөөрөх болон итгэн үнэмших эсэхээ хувь хүн бүр эрх чөлөөтэй бөгөөд ямар ч дарамт шахалтгүйгээр шийдэх учиртай юм.

Тиймээс шаталсан сургалтын бүх номын хувьд чухал зүйл болох ойлгохуй хэмээх асуултаар энэхүү эхний ном эхэлж буйд гайхах зүйл үгүй биз ээ. Ариун Сургаал Бичмэлээс уншина гэдэг нь хүн амьдралынхаа туршид тааралддаг хэдэн мянган хуудастай ном уншихтай огт адилгүй. “Бахайн Сургаал Бичмэлийг Ойлгон Тунгаахуй” бүлэг нь Ариун Бичвэрээс өдөр бүр уншин, түүнийхээ утга санааг тунгаан бясалгах дадлыг хэвшүүлэхэд зорьдог ба энэ дадал нь үйлчлэхүйн зам мөрөөр замнах явцад нь оролцогчдод тун их тус болох болно. Энэ номыг судлах явцад оролцогчдыг хөтлөн чиглүүлэхдээ сургагч нь ойлгон тунгаахуй гэдэг нь юу гэсэн үг болох тухайд маш их ач холбогдол өгөх учиртай юм.

Бахайн Сургаал Бичмэл оюун санааны гүн гүнзгий үнэнийг агуулдаг ба хэдий бид тэдгээрийн цаглашгүй их утга санааны тухай ойлголтоо улам нэмэгдүүлэхээр чармайдаг ч бид эцсийн төгсгөлд нь хэзээ ч үл хүрнэ гэдгээ мэдэх билээ. Бид эшлэл сургаалыг эхний удаа уншаад шууд утгынх нь талаар анхан шатны ойлголтод хүрдэг бөгөөд энэ бүлгийн Нэгдүгээр Хэсэг яг ийм зүйлээс эхэлдэг. Тийм ч учраас “Дэлхий ертөнцийн сайн сайхан байдалд ариун нандин буянт үйлс бүтээж, сайшаалтай бахархмаар байдлаар биеэ авч явснаар хүрч чадна.” гэсэн эшлэлийг уншсаны дараа оролцогчдоос “Дэлхий ертөнцийн сайн сайхан байдалд хэрхэн хүрч болох вэ?” хэмээх энгийн асуултыг асуудаг. Өнгөцхөн харвал иймэрхүү төрлийн асуулт, дасгалуудын ихэнх нь хэт энгийн харагдаж болно. Гэвч ийм байдлаар эхлэх гэсэн Институтийн шийдвэр нь олон жилийн туршлагаас зөв болох нь нотлогдож байгаа юм. Аливаа эшлэл сургаалд буй олон түвшний үнэнийг олж мэдэхээр тэмүүлэх зуур түүний илэрхий тод утга санааг нь анзааралгүй орхиж болохгүй гэдгийг бид бүгд санаж байх хэрэгтэй. Бүлгээрээ зөвлөлдөх зөвлөлдөөнд энэхүү ойлголтын эхний түвшинд анхаарал хандуулах нь амин чухал гэдэг нь харагдсан, учир нь, хувийн санаа бодлуудаа Тэнгэрлэг мэргэн ухаанаар гэрэлтүүлснээр амархан хүрч чаддаг бодол санааны эв нэгдлийг энэ нь батжуулдаг билээ.

Ихэнх эшлэл сургаалын шууд утга санааг ойлгоход контекстээс нь үгийг салган авч удаан хэлэлцэх явдал нь тус нэмэр болохгүй гэдгийг энд чухалчлан тэмдэглэх нь зүйтэй юм. Гэвч зарим тохиолдолд толь бичгээс ганц нэг үгийг бүлгээрээ хайж ажиллах нь чухал байж болох билээ. Гэхдээ өгүүлбэр болон цогцолборыг бүхэлд нь харж аливаа үгсийн утгыг тодорхойлж сурах нь оролцогчдод илүү үр өгөөжтэй байх болов уу.

Шууд утгаас хальж цаана нь буй утга санааг ойлгоход, тодорхой санааг бодитоор илэрхийлж болохыг харуулсан жишээнүүд тус болох нь зүй. Үүнтэй холбоотойгоор оруулсан үйл ажиллагаанууд нь энгийн дасгалууд байгаа. Тухайлбал, Хоёрдугаар Хэсэгт сая судалсан эшлэл сургаалтайгаа холбогдуулан тодорхой хэдэн зан чанарууд сайшаагууштай эсэхийг тодорхойлохыг оролцогчдоос хүсдэг. Дөрөвдүгээр Хэсэгт багтсан үүнтэй төстэй өөр нэг дасгалд таван сайн сайхан зан чанарыг нэрлэх ба эдгээр нь, Сургаал Бичмэлд “хүмүүний бүхий л сайн



сайхан зан чанарын үндэс суурь” хэмээн заасан үнэнч шударга зан чанаргүйгээр байх боломжтой эсэхийг тунгаадаг билээ.

Уг бүлгийн зорилгод хүрэхийн тулд уншиж судалсан эшлэл сургаалууд амьдрал дээр ямар утга учиртай болох талаар оролцогчдоор эргэцүүлж бодуулах замаар ойлголтоо гүнзгийрүүлэхийг шаарддаг. Хоёрдугаар Хэсэгт “Дэлхий дээр сайн хүн цөөхөн байдаг учир тэдний үйлдэл ямар ч үр нөлөөгүй.” хэмээх өгүүлбэрийн үнэн эсэхийг тодорхойлдог. Энд ердөө л оролцогчдын бодол санааг сонсоход зорилго оршиж байгаа бус юм. Харин сургагч түр зогсоож, оролцогчдын өгсөн хариултын шалтгаан нь юу байгааг лавлан асуух ёстой. Энэ өгүүлбэр нь өмнөх Хэсгийн эхний эшлэлтэй зөрчилдөж байгаа тул яах аргагүй буруу хариулт болно гэдэг дүгнэлтэд бүлгээрээ хүрэх хэрэгтэй юм. Бахайчууд бусдад нүглээ наманчилж болох эсэх асуулт нь мөн энэ төрлийн нэг дасгал юм. Энэ нь, өмнөх эшлэл сургаалуудад нь илэрхий тод хэлээгүй ч гэлээ гэм нүглээ цайруулах зорилгоор лам санваартанд нүглээ наманчлахыг сургаал бичмэлд хориглосон байдагтай холбогдож байгаа бөгөөд үүнийг “Эцсийн тооцоо хийгдэхээс өмнө амьдралынхаа зам мөрийн тооцоог өдөр бүр тунгааж бай...” гэсэн эшлэлээс ухаж ойлгох учиртай юм.

Сургаал эшлэлүүдэд агуулагдаж буй утга санааны хүрээг ямар ч утгаараа хязгаарлах зорилго энэ бүлгийн дасгалуудад үгүй билээ. Сургагч бүрийн цэгнэн бодох ёстой нэг асуулт бол аливаа өгөгдсөн дасгалтай холбогдуулж хэр их хэлэлцүүлэг өрнүүлэх тухай юм. Энд санаж байх ёстой нэгэн чухал зүйл бол, холбоотой гэж үзэн нэмэлт санаануудыг оруулан хэлэлцүүлгийн явцыг сунжруулах нь судалж буй материалын үр нөлөөг бууруулах магадлалтай байдаг. Номыг судалж буй бүлэг бүр боломжийн гэсэн хурд хэмнэлтэй болох шаардлагатайгаас гадна, оролцогчид өөр өөрсдийн боломжоороо байнга урагшилж байгаагаа тодорхой хэмжээнд мэдэрч байх учиртай юм. Гэхдээ нөгөө талаас сургагч нь дасгал ажлуудыг нухацтай ажиллалгүйгээр асуултуудад нь хариулаад өнгөрөх төдий хэтэрхий шуурхай, өнгөцхөн хийх вий гэдэгт анхаарал хандуулах ёстой юм. Учир нь, ийм маягаар хэт хөнгөн хандлагаар номыг судалсан урд урдын туршлагаас харахад тэндээс хэзээ ч урт хугацааны үр дүн гардаггүй гэдэг нь харагдсан юм.

Эцэст нь, дурдахаас аргагүй бас нэг зүйл байна: энэ материалын дэмжин тэтгэдэг суралцахуйн үйл явцад бүлгийн гишүүн бүрийн оролцоог хангах үүрэг сургагчид оногддог. Аливаа оролцогчийг хүчилж шахахгүйгээр тэгсэн хэр нь ярих нөхцөл бололцоог нь хангана гэдэг үргэлж бэрхшээлтэй байдаг. Харин, “Таны хувьд энэ нь юу гэсэн үг вэ?” гэх мэт асуулт асуух нь иймэрхүү бэрхшээлийг тойрон гарахад тусалдаггүй гэдгийг анхнаасаа ойлгож мэдэж байх ёстой. Ийм маягийн асуултууд нь мэдлэг ба үнэнийг тухайн хүний үзэл бодлоор төлөөлүүлэх хэмжээнд дордуулах гээд байдаг. Улмаар, бүлгээрээ зөвлөлдөх зөвлөлдөөнөөс ойлголт мэдлэг нэмэгддэг байх тийм орчныг бүрдүүлэхэд улам хэцүү болгодог гэдэг нь харагдсан юм.

Номын хоёр дахь бүлэгт мөн эхний бүлгийн адилаар оюун санааны амьдралд нэн чухал дадлын талаар судлах бөгөөд энэ тохиолдолд тогтмол мөргөл бясалгал үйлдэх хэмээх сэдвийг үзэх юм. Бүлгийн эхний хэсэгт “Үйлчлэхүйн зам мөр” хэмээх ухагдахууныг авч үзэх бөгөөд энэхүү зам мөрөөр алхахдаа бид хоёр талт зорилгыг эрхэмлэн явахыг санал болгодог. Оролцогчид энэхүү хоёр талт зорилгын мөн чанарын талаар гүнзгий ойлголт өгөх учиртай эхний багц эшлэлүүдийг судлах бөгөөд дараа дараагийн цуврал сургалтуудад уг сэдвийг илүү дэлгэрүүлж үзэх болно.

Энэ ерөнхий сэдвийн хүрээнд, уг бүлэгт мөргөлийн ач холбогдлын талаар авч үздэг. Ингэхдээ өмнөх цогцолборуудад дүрсэлсэнтэй төстэй арга замаар хийх болно. Энд буй асуулт, дасгалууд нь оролцогчдын судалж буй Сургаал Бичмэлээс авсан эшлэлүүдийн утга санааг гүнзгийрүүлэн ойлгоход туслах зорилгоор боловсруулагдсан байдаг. Энэ бүлгийн хэсгүүдийг цааш нь судлах явцад сургагч өнгөрсөн үед аливааг хөрвүүлж ойлгох болон амьдрал дээр

хэрэгжүүлэх явцад бий болсон буруу зөрүү ойлголтуудтай холбоотой эргэлзээ тээнэгэлзээг тайлж залруулах шаардлага хэрэгцээ үүсдэг. Зарим уламжлал соёлд хүмүүний дотоод төлөв байдлын ач холбогдол нь аажимдаа элдэв зан үйл, ёс заншилд дарагдан бүдгэрсэн байдаг. Үүний улмаас олон хүн мөргөн залбирахын ач холбогдлыг үл тоомсорлодог болсон байдаг, гэтэл энэ бол хүний сүнсний хувьд бие махбодод хоол тэжээл ямар хэрэгтэй байдгаас ч дутуугүй хэрэгцээтэй нэн чухал зүйл билээ.

Тиймээс юу юунаас чухал нь, энэ бүлгийн хичээлүүд оролцогчдод “Бурхантай харилцах яриа”, Түүнд ойртон дөхөх хүсэл сонирхлыг бий болгохыг зорьж байгаад оршино. Энэ бүлэгт мөн мөргөлийн байдалд нэвтрэн орох гэдэг нь юу гэсэн үг болох, ингэснээр бидний зүрх сэтгэл, оюун бодол ямархуу нөхцөл байдалтай байх, ганцаар аль эсвэл олноор цугласан ч бай өөрсдийн орчин тойрондоо бүрдүүлэх шаардлагатай нөхцөл байдал зэрэг санаануудыг авч үзнэ. Чухамдаа, олуулаа мөргөн сүсэглэхэд тэндээс ямар их хүч үүсдэг тухай судалж хэлэлцсэний дараа оролцогчдыг хамтдаа мөргөн залбирах зорилго бүхий цуглааныг зохион байгуулах талаар бодож үзэхийг хүсдэг.

“Үхэл ба Амьдрал” хэмээх гуравдугаар бүлгийг судалснаар үйлчлэхүйн зам мөрөөр алхах шийдэмгий хүсэл зоригийг улам хурцалж, илүү их утга учиртай болгож өгнө хэмээн итгэн найдаж байна. Энэ дэлхий ертөнцөд үйлчилнэ гэдгийг, “газар дэлхийн оршихуйгаас хальж, бидний сүнс Бурханы ертөнцүүдээр дамжин хөгжих хэрээр үүрд мөнхөд үргэлжилдэг” тийм амьдралын хүрээнд авч үзсэн цагт бүрэн утга санаа нь тодордог билээ. Мэргэжлийн сургалтаас огт өөр зүйл болох энэхүү боловсролын үйл явцад, оролцогчид хийж байгаа зүйлийнхээ утга учир, ач холбогдлыг улам ихээр ухамсарлан ойлгох хэрэгтэй. Зөвхөн ийнхүү ухамсарлан ойлгох нь нэмэгдсэнээр, тэд суралцах үйлийнхээ идэвхтэй бөгөөд хариуцлагатай “ээд” нь чухам өөрсдөө юм хэмээн олж хардаг гэдгийг туршлага нотлон харуулж байгаа билээ.

Уг бүлгийн хэсэг бүр Бахайн Сургаалаас авсан нэгээс гурван эшлэлүүдээр эхлэх ба араас нь дасгал ажлууд орж байгаа. Энэ бүлэгт эш татагдсан сургаал эшлэлүүдийн үг хэллэг нь өмнөх хоёр бүлэгт байгаагаас илүү хүнд байх болно. Гэхдээ мэдээж материалыг судалж буй бүлгийнхэн бэрхшээлтэй үгнүүд дээр хэт төвлөрөн сунжруулах шаардлагагүй бөгөөд сургагчийн зүгээс оролцогч бүр тухайн хэсгийн гол санааг ойлгож авахад анхаарал хандуулах учиртай юм. Дасгал ажлуудын зорилго ч чухам үүнд байдаг билээ.

Бүлгийн сэдвийн мөн чанараасаа хамаараад энд бодит биет жишээг агуулсан дасгалууд маш цөөн орсон буй. Учир нь ихэнх жишээнүүд нь ойлголт ухагдахууны түвшнийх юм. Анхаарах ёстой нэг зүйл бол дасгал ажлуудын зарим асуултад яг таг, тов тодорхой хариулт хайх боломжгүй гэдгийг санаж байх хэрэгтэй. Тэдгээрийг сэдэвтэйгээ илүү танил дотно болоход тань туслах зорилгоор оруулсан бөгөөд оролцогчид иймэрхүү асуултаудын тухай бодож байгаа бол суралцахуйн зорилго нь тийнхүү бүтэх болно.

Эхний хэдэн хэсэгт сүнс ба бие махбодын хоорондын харилцаанд голлон төвлөрнө. Тэдгээр нь хамтдаа нийлж байж оршихуйн ертөнц дэх хүмүүнийг бүрдүүлдэг. Энэ хэсгүүдэд танилцуулагдаж буй гол санаа нь дараах байдалтай байна: Сүнс нь биет зүйл бус, сүнс ба бие махбод хоорондын холбоосыг толинд тусах гэрэлтэй адилтган үзэж болно. Гадаргууд нь тоос бүрхсэн ч бай, эцэстээ толь хагарч хэмхэрдэг ч бай, аль нь ч гэрлийн сүр жавхааг үгүй хийж чадахгүй юм. Үхэл бол бие махбод болон сүнсний холбоос тасрахад үүсэх нөхцөл байдлын өөрчлөлт бөгөөд дараа нь сүнс Бүтээгчийнхээ зүг үүрд мөнхөд хөгжин дэвждэг.

Бүлгийн дараагийн хэсгүүдэд хүмүүний амьдралын зорилго болох Бурханыг таньж мэдэх ба Түүний оршихуйд хүрэх хэмээх асуудлыг авч үзнэ. Энд хэлэлцүүлэг хоёр өргөн сэдвийн хүрээнд явагдана. Эхнийх нь, энэ ертөнц дэх бидний амьдралын зорилго, хоёр дахь нь үхлийн

дараах сүнсний аялал. Сүнс бол Бурханы шинж тэмдэг бөгөөд Түүний бүх нэр алдар ба шинж чанарыг тусган илэрхийлэх чадавхтай. Энэхүү нөөц чадавх нь хүмүүний дотоодод угийн заяагдмал байдаг хэдий ч хүн төрөлхтнийг хөглөн чиглүүлэхээр эрин үеэс эрин үед ирдэг тэдгээр ариуссан Оршихуй болох Бурханы Тодруулагчдын тусламжтайгаар л илрүүлэн хөгжүүлж чадах юм. Өөрөөр хэлбэл, Тэдний өгсөн оюун санааны боловсролоор дамжин бидний доторх нуугдмал эрдэнэс баялаг нээн илрэх боломжтой юм.

Үхлийн дараах сүнсний аялалтай холбоотойгоор оролцогчдод бясалган тунгаахад нь зориулан хэд хэдэн цуврал санаануудыг энд танилцуулдаг. Үүнд: Бурханд бат үнэнч тэр хүмүүс жинхэнэ аз жаргалд хүрч чадна. Бидний хэн нь ч өөрсдийн төгсгөл ямар байхыг хэзээ ч мэдэж чадахгүй, тиймээс бид нэгнээ өршөөн уучилж, өөрийгөө бусдаас давууд үзэж болохгүй. Энэ ертөнцөд болдгийн адилаар дараагийн ертөнцөд ч мөн адил сүнс үргэлжид хөгжин дэвшиж, бидний энэ амьдралдаа хөгжүүлсэн оюун санааны авьяас билгүүд бидэнд тэнд ч тус болсоор байх болно. Бид дараагийн ертөнцөд хайрт хүмүүсээ танихаар барахгүй энэ ертөнц дэх амьдралаа дурсан санаж, ариун гэгээн, ариуссан сүнснүүдтэй нөхөрлөх болно.

Бүлгийн төгсгөлд дараагийн ертөнцийн ашиг тусын талаар баталгаажуулан, энэ ертөнц дэх өөрчлөлт, тохиолдлуудаас үүдэн уйтгар гунигт автах хэрэггүйг сургасан Бахауллагийн Сургаал Бичмэлээс авсан эшлэл буй. Эцэст нь, оролцогчдыг эндээс суралцсан зүйлс өөрсдийнх нь амьдралд ямар утга учир, үр нөлөө үзүүлэх талаар эргэцүүлэн тунгаахыг хүсдэг.





# Бахайн Сургаал Үгсийг Ойлгон Тунгаахуй

## Зорилго

Ариун Сургаал үгсээс өдөр бүр уншиж судлах,  
тэдгээрийнхээ утга санааг бясалган  
эргэцүүлэх дадлыг бататган бэхжүүлэх



# 1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Энэхүү бүлгийн зорилго нь Ариун Сургаал үгсээс өдөр бүр уншиж судлах, тэдгээрийнхээ утга санааг бясалган эргэцүүлэх дадлыг бататган бэхжүүлэхэд тань туслахад оршиж буй юм. Эхлээд нэг л өгүүлбэрээс бүрдсэн эшлэлийг уншиж, асуултад хариулахдаа тухайн эшлэлийг хэлэх маш энгийн дасгал хийнэ. Хэдийгээр их энгийн боловч эл дасгал нь тухайн сургаалын утга санааг эргэцүүлэн тунгааж, цээжлэхэд тус дөхөм болно.

**“Дэлхий ертөнцийн сайн сайхан байдалд ариун нандин буянт үйлс бүтээж, сайшаалтай бахархмаар байдлаар биеэ авч явснаар хүрч чадна.”<sup>1</sup>**

1. Дэлхий ертөнцийн сайн сайхан байдалд хэрхэн хүрч болох вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Ам ажил нь зөрдөг хүмүүсийн замаар явахаас болгоомжлогтун, аяа, Баха-н хүмүүс ээ.”<sup>2</sup>**

2. Бид ямар замаар явах ёсгүй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Аяа, Ахуйн үр! Эцсийн тооцоо хийгдэхээс өмнө амьдралынхаа зам мөрийн тооцоог өдөр бүр тунгааж бай...”<sup>3</sup>**

3. Бид эцсийн тооцоо хийгдэхээс өмнө яах ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Хэлэгтүн: Аяа, ахан дүүс! Ам хэл бус, ажил хэрэг тань дээдийн чимэг болог!”<sup>4</sup>**

4. Бидний дээдийн чимэг юу болох ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Ариун үг яриа ба цэвэр ариун, эрхэм сайхан ажил үйлс нь хурмастын алдрын диваажин өөд дүүлэн дэвжих болмуй.”<sup>5</sup>**

5. Ариун үг яриа, цэвэр ариун, эрхэм сайхан ажил үйлс нь яадаг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 2 ДУГААР ХЭСЭГ

Өмнөх хэсэгт таны судалсан эшлэлүүдтэй холбоотой хэд хэдэн дасгал доор байна. Эдгээрийн зорилго бол дээрх эшлэлүүдийн утга учир, ач холбогдлын талаар бүлгээрээ гүнзгийрүүлэн эргэцүүлэхэд тань тус болоход оршиж байгаа бөгөөд эднийг ажиллахдаа бодох юмгүй шууд хийх хэрэггүй. Гэхдээ дасгал болгон дээр хэт нуршуу хэлэлцүүлэг өрнүүлэх бас шаардлагагүй юм. Зарим дасгал амаргүй байвал нухацтай судлахад тань сургагч танд туслах болно.

1. “Сайшаалтай” гэдэг нь магтаал хүртэхүйц гэсэн утгатай юм. Дараахын аль нь сайшаалтай вэ?

- Сайн ажилтан байх?
- Бусдыг хүндлэх?
- Хичээл чармайлттай байх?
- Худалч байх?
- Залхуу байх?
- Бусдыг хөгжиж дэвшихэд нь туслах?

2. “Эцсийн тооцоо хийгдэхээс өмнө” гэсэн нь юу гэсэн утгатай вэ? \_\_\_\_\_

3. Дараах зүйлс үнэн худлын аль нь болохыг ол:

- Дэлхий дээр сайн хүн цөөхөн байдаг учир тэдний үйлдэл ямар ч үр нөлөөгүй.
- Бусад хүмүүсийн санал бодолтой нийцэж байгаа бол тэр зүйл үнэн зөв.
- Бурханы сургаалтай нийцэж байгаа бол тэр зүйл үнэн зөв

4. Дараахын аль нь цэвэр ариун, эрхэм сайхан ажил үйлс вэ?

- Хүүхэд багачуудыг халамжлах, тэдэнд багшлах
- Хулгай хийх
- Бусдын хөгжил дэвшлийн төлөө мөргөн залбирах
- Хүндрэлтэй байдлаас гарахын тулд бага зэрэг худал хэлэх
- Бусдад туслаад хариу горьдох

5. Дараах тохиолдлуудын алинд тухайн хүний үг яриатай үйлдэл нь нийцэхгүй байна вэ?

- Бид нар эв нэгдэлтэй байх хэрэгтэй шүү дээ гэж байн байн ярих хэр нь байгаа байдал нь зөрчил тэмцэл үүсгэхэд чиглэдэг.



\_\_\_\_\_ Ариун журамт амьдралын үнэ цэнийг чухалчилж ярих хэр нь гэр бүлээсээ гадуур бэлгийн харилцаатай.

\_\_\_\_\_ Архи уухыг хориглодог шашны итгэл үнэмшлийг баримталдаг атлаа үе үе архи дарс хэрэглэдэг.

\_\_\_\_\_ Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн тэгш эрхийг өмгөөлөн тэмцдэг хэр нь ажил олгогчийнхоо хувиар эмэгтэй ажилтнууддаа яг ижил ажил хийсэн эрэгтэй хүнд төлдгөөс багыг төлдөг.

6. Бахай хүн өөр нэгэн хүнд нүглээ наманчлах нь зөвшөөрөгддөг үү? \_\_\_\_\_

7. Нүглээ наманчлахын оронд яах ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

8. “Хурмастын алдрын диваажин” гэж юу гэсэн үг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

9. Буруу муу үйлдэл нь ертөнцөд ямар нөлөө үзүүлдэг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

10. Муу үйлдэл хийж байгаа хүмүүст энэ үйлдэл нь ямар нөлөө үзүүлэх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

### 3 ДУГААР ХЭСЭГ

Сургаалаас авсан дараах эшлэлүүдийг уншаад эргэцүүлнэ үү. Дараа нь цээжлэхийг хичээгээрэй.

**“Үнэнч шударга зан чанар бол хүмүүний бүхий л сайн сайхан чанарын үндэс суурь нь мөн.”<sup>6</sup>**

1. Хүмүүний бүхий л сайн сайхан чанарын үндэс суурь нь юу вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Үнэнч шударга зан чанаргүйгээр ямар ч хүн Бурханы ямар ч ертөнцөд хөгжин дэвшиж, амжилт олох боломжгүй.”<sup>7</sup>**

2. Үнэнч шударга зан чанаргүйгээр юу боломжгүй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Аяа, хүмүүс ээ, хэл яриагаа үнэнч шударга чанараар ариусгаж, зүрх сэтгэлээ шударга үнэний хээ угалзаар чимэглэгтүн.”<sup>8</sup>**

3. Бид хэл яриагаа юугаар ариусгах ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

4. Бид зүрх сэтгэлээ юугаар чимэглэх ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Мэлмий тань цэвэр тунгалаг, мутар тань үнэнч, хэл яриа тань шударга, зүрх сэтгэл тань гэгээрсэн байгтун.”<sup>9</sup>**

5. Бидний мэлмий ямар байх ёстой вэ? \_\_\_\_\_ Бидний мутар?  
\_\_\_\_\_ Бидний хэл яриа? \_\_\_\_\_ Бидний зүрх сэтгэл?  
\_\_\_\_\_.

**“Бурханы асарт оршиж, ашид мөнхийн алдрын суудалд залрагсад нь өлсөж үхэх гэж байсан ч, хөрш анд нь хэчнээн олиггүй доорд, дорой нэгэн байсан ч бай, түүний эд хөрөнгөнд хууль бусаар гар хүрч, эзэмдэхээс татгалзана.”<sup>10</sup>**

6. Өлсөж үхэх гэж байсан ч Бахай хүн юунаас татгалзах ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## **4 ДҮГЭЭР ХЭСЭГ**

Хоёрдугаар Хэсэгт таны анзаарсанчлан зарим дасгалыг хийхэд яг таг тодорхой хариу өгөх шаардлагатай байсан билээ. Ийм тохиолдолд хэрэв хариулт нь тодорхой бус, эргэлзээтэй санагдвал сургагч тань та бүхэнд бодол санаа, ойлголтын нэгдэлд хүрэхэд туслах нь дамжиггүй. Харин бусад төрлийн дасгалын хувьд гэвэл, зөвлөлдөн ярилцаж байгаа нь өөрөө чухал тул яг тодорхой нэг хариулт хүсэн хүлээх шаардлагагүй юм. Доор буй 3 дахь дасгал нь эхний төрөлд багтах бол харин 6 дахь дасгал нь хоёр дахь төрөлд багтах юм.

1. Үнэнч шударга зан чанар бол хүмүүний бүхий л сайн сайхан чанарын үндэс суурь нь мөн билээ. Сайн сайхан чанараас тавыг бичнэ үү: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

2. Бид эдгээр зан чанарыг үнэнч шударга зан чанаргүйгээр эзэмшиж чадах уу?  
\_\_\_\_\_

3. Дараахын аль нь үнэн болохыг олно уу:

- \_\_\_\_\_ Хүн худлаа хэлдэг ч үнэнч шударга байж болно.
- \_\_\_\_\_ Хулгай хийдэг хүн үнэнч мутартай.
- \_\_\_\_\_ Үнэнч мутар нь өөрийнхөө бус юманд хэзээ ч хүрдэггүй.
- \_\_\_\_\_ Садар самууны ном сэтгүүл унших нь мэлмийгээ цэвэр тунгалаг байлга гэсэн Бахауллагийн сургаалд үл нийцнэ.
- \_\_\_\_\_ Үнэнч шударга байна гэдэг нь худал хэлэхгүй гэсэн үг.
- \_\_\_\_\_ Шударга үнэнч чанар бол зүрх сэтгэлийн чимэг юм.
- \_\_\_\_\_ Үнэнч шударга биш хүн оюун санааны хувьд хөгжиж чадна.
- \_\_\_\_\_ Хааяа, хааяа худал хэлбэл зүгээр.
- \_\_\_\_\_ Өлссөн үедээ хулгай хийх нь Бурханы номд зөвшөөрөгдсөн.
- \_\_\_\_\_ Дараа нь эргүүлж өгнө гэж бодоод эзнээс нь зөвшөөрөл авалгүй ямар нэгэн зүйлийг авах нь хулгай биш.
- \_\_\_\_\_ Хэрэв бид аливааг үнэнчээр хийж, шударга үнэнч хандлагатай байж чадвал зүрх сэтгэл маань гэгээрнэ.
- \_\_\_\_\_ Бага зэрэг хуурч хулхидахгүйгээр бизнесийг амжилттай хийнэ гэдэг бүтэшгүй зүйл.

4. Хүн өөртөө худал хэлж хуурах боломжтой юу? \_\_\_\_\_

5. Бид худал ярьснаар юугаа алддаг вэ? \_\_\_\_\_

6. Хэрэв бид бүгдээрээ шударга бөгөөд үнэнч байсан бол дэлхий ертөнц ямар байх байсан бол? \_\_\_\_\_

## 5 ДУГААР ХЭСЭГ

Дараах эшлэлүүдийг уншаад, цээжилнэ үү. Сургаалаас авсан эшлэлүүдийг цээжлэх нь маш их ач тустай байдаг тул та хамгийн сайнаараа хичээгээрэй. Энэ нь гэхдээ хүн бүрийн хувьд хялбар байхгүй гэдэг нь мэдээжийн хэрэг. Гэхдээ цээжлэхээр ийнхүү хичээн чармайх явцад утга санаа нь бидний сэтгэлд хадгалагдан үлдэх, улмаар эх сургаалтай нь аль болох ойр хэлээр санаагаа илэрхийлж сурахад дөхөмтэй байдаг билээ.

**“Эелдэг элэгсэг хэл яриа нь хүмүүсийн зүрх сэтгэлийн соронзон гүр\* буй заа. Энэ нь оюун санааг тэжээж, үг үсгийг утга учиртай болгох ба үүнээс цэцэн мэргэн ухаан ба ухаарлын гэрэл оргилон ундардаг.”<sup>11</sup>**

*\*(соронздон татах шинж чанартай нэгэн төрлийн чулуу Орч.)*

1. Эелдэг элэгсэг хэл яриаг хэрхэн дүрсэлж болох вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

2. Эелдэг элэгсэг хэл нь үг ярианд хэрхэн нөлөөлдөг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Аяа, Эзэн тэнгэрийн хайрт шавь нар! Энэхүү ариун Сургаал номлолд зөрчилдөөн, хэрүүл маргаан огт үл зөвшөөрөгдөнө. Түрэмгий байдал гаргаж байгаа хэнд ч Бурханы буян хишиг хүртээлгүй болой.”<sup>12</sup>**

3. Дээрх эшлэлээс үзвэл энэхүү Сургаал номлолд юуг цээрлэдэг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

4. Түрэмгий байдал гаргаж байгаа хүнд юу хүртээлгүй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Энэ Өдөр Бурханы хайрт шавь нарын хооронд хэрүүл тэмцэл, маргаан, хүйтэн цэвдэг, хайхрамжгүй байдал гарахаас илүү энэхүү Үйл хэрэгт хор хөнөөл учруулах зүйл үгүй билээ.”<sup>13</sup>**

5. Бурханы Үйл хэрэгт ямар нөхцөл байдал хамгийн их хор хөнөөл учруулах вэ?  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Зөвхөн үгээр л илрэх эвсэг нөхөрсөг чанараар сэтгэл бүү ханагтун, замд тань учран таарах**

**хүн бүрийг хайрлах хайрын сэтгэлээр зүрх сэтгэлээ гэрэлтүүл.”<sup>14</sup>**

6. Бид ямар маягийн эвсэг нөхөрсөг чанараар сэтгэл ханах ёсгүй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

7. Бидний зүрх сэтгэлийг юу гэрэлтүүлэх ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

**“Дайн дажны тухай бодол төрөх аваас түүнийг энх тайвны тухай илүү хүчтэй бодлоор эсэргүүцэгтүн. Үзэн ядах сэтгэл улам хүчтэй хайрлах сэтгэлийн дор унтрах ёстой.”<sup>15</sup>**

8. Дайны тухай бодлыг бид юугаар эсэргүүцэх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
9. Үзэн ядах сэтгэл юунд унтрах ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 6 ДУГААР ХЭСЭГ

Дээрх эшлэлүүдийг санангаа дараах дасгалуудыг хийнэ үү:

1. “Соронзон гүр” гэдэг нь соронзыг илэрхийлэх өөр нэгэн үг юм. Эелдэг элэгсэг хэл яриа нь хэрхэн соронзон гүр мэт байж чадах вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Дараах үгсийн аль нь эелдэг хэл ярианы шинж вэ?
- \_\_\_\_\_ “Надад битгий саад болоод бай!”
- \_\_\_\_\_ “Чи ер нь үүнийг яагаад ойлгодоггүй юм бэ?”
- \_\_\_\_\_ “Та жаахан хүлээж байна уу?”
- \_\_\_\_\_ “Ямар аймаар хүүхдүүд вэ!”
- \_\_\_\_\_ “Баярлалаа. Та их сайхан сэтгэлтэй хүн юм.”
- \_\_\_\_\_ “Чамд гаргах цаг алга. Би завгүй байна.”
3. Дараах тохиолдлуудын алинд нь зөрчилдөөн сөргөлдөөн илэрч байна вэ?
- \_\_\_\_\_ Зөвлөлдөж ярилцах үеэр нэг асуудлаар хоёр хүн хоёр өөр үзэл бодол илэрхийлж байна.
- \_\_\_\_\_ Зөвлөлдөж ярилцах явцад хоёр хүн муудалцан маргалдаж байна.
- \_\_\_\_\_ Долоо хоног тутам явагддаг мөргөлийн цуглаанд хоёр хүн оролцохоо больжээ, учир нь тэд нэгэнтэйгээ ярих сонирхолгүй болсон.
- \_\_\_\_\_ Нэгэн төсөл дээр ажиллаж буй хоёр хүн нэг нэгнийгээ өөрийн хариуцсан үүргээ биелүүлэхгүй байна гэж байнга гомдоллож байна.
4. Дараахын аль тохиолдолд хүйтэн цэвдэг, үл хайхрах байдлыг гаргаж байна вэ?
- \_\_\_\_\_ Хоёр найз гудамжинд таарсан ч нэгнийгээ үл хайхран зөрөн өнгөрлөө.
- \_\_\_\_\_ Мөргөлийн цуглаан дээр нэг хүн нэмэгдэн орж ирэхэд тэнд байсан хүмүүс бүгд найрсгаар мэндэллээ.
- \_\_\_\_\_ Хоёр хүн хоорондоо эелдэг харилцаж байгаа ч нэг төсөл дээр хамт ажиллахаас татгалзаж байна.

5. Дараах үгсийн үнэн худлын аль нь болохыг олоорой:

\_\_\_\_\_ Хүний сэтгэлийг гомдоох эсэх нь хамаагүй, аливаа хүн бусдын тухай юу бодож явдгаа шууд хэлэх хэрэгтэй.

\_\_\_\_\_ Зөрчил маргаанаас зайлсхийхийн тулд худал хэлэх нь зүгээр.

\_\_\_\_\_ Аливаа зөрчил маргааныг хайр энэрлээр даван туулж болно.

\_\_\_\_\_ Хайрлах сэтгэлээр хэлсэн үг илүү нөлөөтэй байдаг.

\_\_\_\_\_ Нөгөө хүн чинь асуудлыг анх үүсгэсэн бол түүнтэй маргалдан тэмцэлдэх нь зөв.

\_\_\_\_\_ Хүн өвчтэй юм уу гунигтай үедээ бусадтай ширүүн харьцахад зүгээр.

\_\_\_\_\_ Хүн буруу зүйл хийхэд түүнийг шоолж инээх нь эелдэг хэрэг биш.

\_\_\_\_\_ Анд нөхдийн хооронд бие биедээ гоморхон гомдох байдал үүсвэл аль аль нь нөгөөтэйгөө эвлэрэн сайдахын төлөө чадах бүхнээ хийх хэрэгтэй.

\_\_\_\_\_ Анд нөхдийн хооронд бие биедээ гоморхон гомдох байдал үүсвэл аль аль нь нөгөөгөө эвлэрэх алхам хийхийг хүлээх хэрэгтэй.

## 7 ДУГААР ХЭСЭГ

Доорх эшлэлүүдийг судалж, цээжилнэ үү:

**“...хов живээр хөөцөлдөх явдал нь зүрх сэтгэлийн гэрлийг унтрааж, сүнсний амийг бөхөөдөг болой.”<sup>16</sup>**

**“Өөрөө чи нүгэлтэн мөртөө бусдын нүглийг бүү уудал.”<sup>17</sup>**

**“Муу муухайг сонсохгүй гэвээс муу муухай зүйлийг бүү яригтун, өөрийн алдаа дутагдлыг нэмэхгүй гэвээс бусдын алдаа дутагдлыг бүү томруулан ярь.”<sup>18</sup>**

**“Аяа, Ахуйн үр! Өөрийн алдас нүглийг умартаж бусдын алдаа дутагдлаар завгүй хөөцөлдөж болно гэж үү?”<sup>19</sup>**

1. Хов жив ярьж яваа хүнд өөрт нь энэ нь хэрхэн нөлөөлдөг вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

2. Бусдын алдаа дутагдлын тухай бодохынхоо өмнө бид юуг санаж байх ёстой вэ?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

3. Бусдын алдаа дутагдлыг томруулан ярих юм бол яах вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

4. Бусдын алдаа дутагдлын тухай бодох болбол бид юуг санах хэрэгтэй вэ?

---

---

## 8 ДУГААР ХЭСЭГ

Дээрх сургаал эшлэлүүдийг санангаа дараах дасгалуудыг хийгээрэй:

1. Бусдын алдаа дутагдал дээр төвлөрсөн хүний оюун санааны хөгжил яах вэ?

---

2. Хов живээр хөөцөлдөх явдал нь аливаа нийгэмлэг, хамт олонд ямар хор нөлөө үзүүлэх вэ? \_\_\_\_\_

---

3. Нэгэн танил найз тань өөр нэгэн хүний алдаа дутагдлын тухай танд яриад эхэлбэл та яах вэ? \_\_\_\_\_

---

4. Дараах нь үнэн худлын аль нь болохыг олно уу:

\_\_\_\_\_ Хэн нэгний жинхэнэ алдаа дутагдлын тухай яривал энэ нь хов жив ярьж байгаа явдал биш.

\_\_\_\_\_ Хэн нэгний сайн тал, муу тал аль алийг нь ярьж байвал энэ нь хов жив биш.

\_\_\_\_\_ Хов живээр хөөцөлдөх нь манай нийгэмд түгээмэл үзэгдэл болсон тул бид үүнээс зайлсхийх сахилга батад суралцах хэрэгтэй.

\_\_\_\_\_ Хэрвээ сонсож байгаа хүн нь цаашаа хэнд ч хэлэхгүй гэж амлавал түүнд өөр нэгний тухай ярихад зүгээр.

\_\_\_\_\_ Хов жив ярих нь эв нэгдлийн хамгийн аюултай дайсан.

\_\_\_\_\_ Хэрвээ бид байнга л бусдын тухай ярьдаг хэвшилтэй болчихвол хов жив ярихад их ойрхон болно.

\_\_\_\_\_ Орон Нутгийн Оюун Санааны Чуулгын уулзалт дээр ямар нэг хороонд томилохын тулд хүмүүсийн чадвар чадавхын талаар хэлэлцэж байгаа нь хов жив ярьж байгаа хэрэг.

\_\_\_\_\_ Бид хов жив яримаар санагдах үедээ өөрсдийн алдаа дутагдлыг санах хэрэгтэй.

\_\_\_\_\_ Хэн нэгэн хүн Шүтлэгт хор хөнөөл учруулах зүйл хийж байгааг мэдвэл бид энэ талаар нийгэмлэгийнхээ гишүүдтэй хэлэлцэх хэрэгтэй.

\_\_\_\_\_ Хэн нэгэн хүн Шүтлэгт хор хөнөөл учруулах зүйл хийж байгааг мэдвэл бид энэ талаар зөвхөн Орон Нутгийн Оюун Санааны Чуулгад мэдэгдэх хэрэгтэй.

\_\_\_\_\_ Гэр бүлийн хоёр бие биеэсээ нуух зүйл байх ёсгүй тул өөр нэг хүний алдаа дутагдлын тухай ярьж болно.

## 9 ДҮГЭЭР ХЭСЭГ

Хамгийн эхэнд хэлсэнчлэн энэ бүлгийн зорилго бол оролцогчдод Ариун Сургаал үгсээс өдөр бүр уншиж судлах, тэдгээрийнхээ утга санааг бясалган эргэцүүлэх дадлыг бататган бэхжүүлэхэд оршиж байгаа билээ. Өглөө оройд Ариун Сургаал үгсээс уншиж байх гэдэг нь бидний оюун санааны хөгжилд чухал нөлөө бүхий Бахауллагийн нэгэн сургаал юм. Дараах эшлэл сургаал нь энэхүү үүргээ гүйцэтгэснээр бидэнд ирэх буян хишгийг сануулдаг бөгөөд үүнийг цээжлэхийг танаас хүсэж байна:

**“Миний үг айлдварын тэнгис далайд шумбан орогтун, чингэснээр түүний далд нууцыг нээж, гүн ёроолд нь нуугдмал мэргэн ухааны сувдан сондруудыг олж илрүүлэгтүн.”<sup>20</sup>**

Энэ бүлгийг судалж дууссан тул одоо харин та Бахауллагийн Сургаал үгсийг агуулсан ямар нэгэн ном олж авч, түүнээс өдөр бүр хэсэг хэсгээр нь уншиж болох юм. Жишээлбэл, “Эрдэнийн нуугдмал үгс” нь таны эхний сонголт байж болох юм.



## ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. Бахаулла, Шоги Эффендигийн “*Advent of Divine Justice*” (“Тэнгэрлэг шударга ёс залрахуй”) номд эш татсанаар (Wilmette, Baha’i Publishing Trust, 1990), хуу.24-25
2. Бахаулла, “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”, СХХХХХ, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), хуу.244
3. Бахаулла, “*Эрдэнийн нуугдмал үгс*”, Араб хэлнээс № 31, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2013 он), хуу.18
4. Мөн дээрхтэй адил, Перс хэлнээс № 5, хуу.41
5. Мөн дээрхтэй адил, Перс хэлнээс № 69, хуу.84
6. Абдул-Баха, Шоги Эффендигийн “*Advent of Divine Justice*” (“Тэнгэрлэг шударга ёс залрахуй”) номд эш татсанаар (Wilmette, Baha’i Publishing Trust, 1990), хуу.26
7. Мөн дээрхтэй адил
8. Бахаулла, “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”, СХХХХХ, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), хуу.238
9. Бахаулла, *Tablets of Baha’u’llah Revealed after Kitab-i-Aqdas* (“Китаб-и-Акдасын дараа Бахауллагийн туурвисан Илгээлтүүд”) (Wilmette, Baha’i Publishing Trust, 1997), хуу.138
10. Бахаулла, “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”, СХХХХХ, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), хуу.239
11. Мөн дээрхтэй адил, СХХХХХ хуу.232
12. *Will and Testament of ‘Abdu’l-Baha* (“Абдул-Бахагийн Хүсэл зориг ба Гэрээслэл”) (Wilmette, Baha’i Publishing Trust, 1991), хуу.13
13. Бахаулла, “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”, V, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), хуу.19
14. Абдул-Баха, “*Парист айлдсан айлдварууд*”, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2002 он), хуу.1
15. Мөн дээрхтэй адил, хуу.11
16. Бахаулла, “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”,СХХХХ, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), хуу.214
17. Бахаулла, “*Эрдэнийн нуугдмал Үгс*”, Араб хэлнээс № 27, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2013 он), хуу.17
18. Мөн дээрхтэй адил, Перс хэлнээс № 44, хуу.67

- 
19. Мөн дээрхтэй адил, Араб хэлнээс № 26, хуу.16
  20. Бахаулла, “Бахауллагийн Сургаалын Дээжис”, LXX, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), хуу.116



# Мөргөл

## Зорилго

Мөргөлийн ач холбогдлын талаар эргэцүүлж,  
тогтмол мөргөл үйлдэх дадлыг хэвшүүлэх



# 1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Рухи Институтийн сургалтуудын зорилго нь оролцогчдыг үйлчлэх зам мөрөөр замнахад нь туслахад оршдог билээ. Энэ замаар бид оюун санаа, оюун ухааны хувьд хөгжин дэвших, мөн нийгмийн хувьсал өөрчлөлтөд хувь нэмрээ оруулах гэсэн хоёр талтай зорилгод хөтлөгдөн алхдаг. Бидний энэ зорилгын хоёр тал нь хоорондоо салшгүй холбоотой юм. Бахаулла нэгэн илгээлтдээ бидэнд ийнхүү зөвлөн сануулсан байдаг:

**“Зөвхөн өөрийн ажил хэргээ бодон завгүй суухыг цээрлэ. Бодол санаа тань хүмүүн олны ажил үйлсийг сэргээн дэвжээхэд, хүмүүсийн сүнс, зүрх сэтгэлийг ариусган бадрахад шийдэмгий төвлөрөг.”<sup>1</sup>**

Мөн өөр нэгэн сургаалдаа Тэрээр ийнхүү айлджээ:

**“... мөнх бус хүмүүн огтын оргүйгээс оршихуйн энэ ертөнц рүү хөл тавин ирсний зорилго нь дэлхий ертөнцийг илүү сайн болгохын төлөө хөдөлмөрлөж, эв нийц, эе найртайгаар хамтран амьдрахад оршин буй.”<sup>2</sup>**

Бидний дотоод нөхцөл байдал ямар байх тухайд Тэрээр ийнхүү тунхаглажээ:

**“Цэвэр ариун зүрх сэтгэл гэдэг бол толь лугаа адил. Түүнийг хайрын сэтгэл хийгээд Бурханаас бусдыг огоорох огоорлоор гялалзуулан өнгөлөгтүн. Чингэвээс, түүнд жинхэнэ үнэн нар тольдон тусаж, мөнхийн өглөөний гэгээ туяарах болно.”<sup>3</sup>**

Харин Абдул-Баха айлдахдаа:

**“Зүрх сэтгэл тань цэвэр ариун, санаа зорилго тань чин сэтгэлийнх байх учиртай, тэгвээс та нар тэнгэрлэг адис ивээлийн хүлээн авагч болж чадна.”<sup>4</sup>**  
гэжээ.

1. Бидний бодол санаа юунд төвлөрч, юунд санаа тавих хэрэгтэй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Огтын оргүйгээс оршихуйн энэ ертөнцөд хөл тавихдаа бид ямар зорилготой ирсэн бэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Зүрх сэтгэлийн толио бид юугаар цэвэрлэх хэрэгтэй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Тэнгэрлэг адис ивээлийг татдаг зарим нэг нөхцөл байдлыг нэрлэнэ үү? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

5. Дараахад үнэн зүйл байна уу?

- Эхлээд чи өөрийгөө болгож байж дараа нь бусдын тухай бод.
- Байнга бусдад туслаад байвал чи эцэст нь өөрийн зорилгоо умартахад хүрнэ.
- Чиний хамгийн сайн найз бол чи өөрөө.
- Хамгийн чухал зүйл бол чамайг баяр хөөртэй болгодог тэр зүйлээ олоход оршино.
- Мөрөөдлөө дагаж амьдар, тэр чинь чамайг баяр жаргалтай болгоно.
- Хэн нэгнийг хохироож гомдоохгүй л бол миний юу хийх нь хэнд ч хамаагүй.
- Чи жаахан ч гэсэн сайн сайхныг бүтээдэг л бол аливааг амин хувиа бодох сэтгэлээр хийхэд зүгээр.

## 2 ДУГААР ХЭСЭГ

Бидний хоёр талт зорилгын гол цөмд нь байдаг итгэл үнэмшил бол хүн анхнаасаа эрхэм сайхан бүтээгдсэн тухай юм. Бахаулла хэлэхдээ:

**“Аяа, Оюун санааны Үр! Би чамайг баян болгож бүтээсэн, юунд чи өөрийгөө ядуу болгоно вэ? Чамайг эрхэм сайхан болгож бүтээсэн, юунд чи өөрийнхөө байр суурийг дордуулна вэ? Эрдэм мэдлэгийн охиор Би чамайг бүтээсэн, юунд чи Надаас бусдаас гэгээрлийг эрнэ вэ? Хайрын сэтгэлийн зуурмагаар Би чамайг урласан, юунд чи бусадтай завгүй зууралдана вэ? Харц мэлмийгээ өөр лүүгээ чиглүүл, чингэвээс хамгаас хүчирхэг, чадалтай, эгнэгт дангаар оршигч Намайг чи өөрийн дотор олж үзэх болно.”<sup>5</sup>**

Хоосон зайг бөглөнгөө энэ эшлэлийнхээ утга санааг эргэцүүлээрэй.

“Аяа, Оюун санааны Үр! Би чамайг \_\_\_\_\_ болгож бүтээсэн, юунд чи өөрийгөө \_\_\_\_\_ болгоно вэ? Чамайг \_\_\_\_\_ болгож \_\_\_\_\_, юунд чи өөрийнхөө байр суурийг \_\_\_\_\_ -ийн \_\_\_\_\_ Би чамайг бүтээсэн, юунд чи \_\_\_\_\_ аас бусдаас \_\_\_\_\_ -ийг эрнэ вэ? \_\_\_\_\_ -ийн зуурмагаар Би чамайг \_\_\_\_\_, юунд чи \_\_\_\_\_ -тай завгүй \_\_\_\_\_ вэ? \_\_\_\_\_ -гээ \_\_\_\_\_ лүүгээ чиглүүл, чингэвээс \_\_\_\_\_, \_\_\_\_\_, \_\_\_\_\_ -г чи өөрийн дотор олж үзэх болно.

Зүрх сэтгэлийнхээ тэрхүү эрхэм сайхан чанарыг илрүүлэхийн тулд бид өөрсдийн оршихуйн Эх үүсвэрийн зүг хандаж, Түүнээс гэгээрлийг эрэн хайх учиртай. Үүнд гарцаагүй хүрэх нэгэн арга зам бол мөргөлөөр дамжиж хүрэх явдал юм. Шүтлэгийн Асран Тэтгэгч Шоги Эффенди хэлэхдээ мөргөлийн эн тэргүүний зорилго нь “хувь хүний болон нийгмийн хөгжилд оюун санаалаг зан чанарууд болон оюун санааны хүчээр дамжин хүрэхэд оршино. Хооллож тэжээх ёстой хамгийн эхний зүйл бол бидний сүнс юм. Харин тэрхүү оюун санааны хоол тэжээлийг мөргөл л хамгийн сайн өгч чадна.”<sup>6</sup> гэжээ.

### 3 ДУГААР ХЭСЭГ

Бурхан бол Бүхнийг Мэдэгч, Бүхнээс Мэргэн ухаантай нь. Бурхан биднийг бүтээсэн бөгөөд бидний зүрх сэтгэлд юу байгааг, бидэнд юу хамгийн сайн болохыг мэддэг. Түүнд бидний мөргөл хэрэггүй. Тэгвэл бид яагаад мөргөл үйлддэг юм бэ?

Абдул-Баха айлдахдаа:

“Хамгийн дээд зэргийн мөргөлийг үйлдэхдээ хүмүүс Бурханаас юм уу тамаас эмээсэндээ бус, эсвэл ямар нэгэн хишиг юм уу диваажинг горьдсондоо биш, гагцхүү Бурханыг хайрласандаа л мөргөдөг... Хүн өөр хэн нэгэнд хайр сэтгэлтэй болоход түүнийхээ нэрийг дурсахгүй байж чаддаггүй шүү дээ. Тэгвэл Бурханыг хайрласан хүн Түүний Алдарыг байнга дурсахгүй байж яахин чадах билээ... Бурханлаг хүн Бурханыг дурсан магтахаас өөр юунаас ч баяр жаргалыг олохгүй.”<sup>7</sup> гэжээ.

Мөн Тэрээр нэгэн асуултад хариулахдаа:

“Хэрэв хүн найзаа хайрладаг бол хайраа илэрхийлэн хэлэхийг хүсэх нь зүй ёсны хэрэг бус гэж үү? Өөрийг нь хайрладгийг найз тань мэддэг байлаа гээд та түүнд хайраа илэрхийлэхийг хүсэхгүй гэж үү?... Бурхан бүх хүний зүрх сэтгэлийг мэддэг нь үнэн, гэвч залбиран мөргөх хүсэл тэмүүлэл нь Бурханд зориулсан хүний хайраас өөрийн эрхгүй ундрэн гардаг юм.”<sup>8</sup> гэсэн байдаг.

1. Дараах өгүүлбэрийг нөхөн гүйцээнэ үү:

a. Хамгийн \_\_\_\_\_ мөргөлийг үйлдэхдээ бид Бурханаас юм уу \_\_\_\_\_ эмээсэндээ бус, эсвэл ямар нэгэн \_\_\_\_\_ юм уу \_\_\_\_\_-г горьдсондоо биш, гагцхүү Бурханыг \_\_\_\_\_ л \_\_\_\_\_.

b. Хүн өөр хэн нэгэнд \_\_\_\_\_-тэй болоход түүнийхээ \_\_\_\_\_-ийг дурсахгүй байж \_\_\_\_\_ шүү дээ. Тэгвэл Бурханыг \_\_\_\_\_ хүн \_\_\_\_\_ Алдарыг байнга \_\_\_\_\_ байж \_\_\_\_\_ билээ.

- с. Бурханлаг хүн Бурханыг \_\_\_\_\_-аас өөр юунаас ч \_\_\_\_\_-ыг олохгүй.
2. Бид яагаад мөргөл үйлддэг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Бурханыг дурсан магтах гэж юу гэсэн утгатай вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Хэн нэгнийг хайрласан хүний хамгийн оргилуун хүсэл нь юу вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
5. Залбиран мөргөх хүсэл тэмүүлэл юунаас ундрэн гардаг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

#### 4 ДҮГЭЭР ХЭСЭГ

Бахауллагийн туурвисан нэгэн мөргөлд ийнхүү өгүүлжээ:

**“Мөргөлийг минь Таны төгс үзэсгэлэнгээс намайг далдлагч халхавчийг хуулан шатаах гал, Таны Оршихуйн далай руу хөтлөх гэрэл гэгээ болгохыг... залбиран гуйя”<sup>9</sup>**

Мөн уг мөргөлд бид Бурханаас гуйн ийнхүү залбирдаг:

**“Эзэн тэнгэр минь, мөргөлийг минь Таны эрх хэмжээ надад зөвшөөрөх тэр бүх хугацаанд намайг амьдруулах, Таны ертөнцүүдийн ертөнц бүхэнд Таныгаа дурсаж явахад минь тэтгэх мөнхийн рашааны ундарга болгож хайрлаач.”<sup>10</sup>**

1. Мөргөл ямар утгаараа гал шиг байх вэ? Юуг шатаах хэрэгтэй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Биднийг Бурханаас халхалдаг зарим нэг халхавчийг нэрлэнэ үү: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Мөргөл гэрэл шиг байж чадах уу? Юу руу биднийг хөтлөх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



4. Мөргөл мөнхийн рашааны ундарга шиг байж чадах уу? Энэ нь бидэнд юуг хайрлах вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

## 5 ДУГААР ХЭСЭГ

Абдул-Бахагийн дараах айлдварыг уншаад эргэцүүлнэ үү.

**“Оршихуйн энэ ертөнцөд мөргөлөөс өөр илүү тансаг сайхан зүйл үгүй билээ. Хүн мөргөлийн байдалд амьдрах ёстой. Хамгийн адист нөхцөл бол мөргөл залбирлын нөхцөл юм. Мөргөл бол Бурхантай харилцах яриа билээ. Хүрч чадах хамгийн агуу дээд түвшин буюу хамгийн тансаг сайхан байдал бол гагцхүү Бурхантай харилцах яриа юм. Энэ нь бурханлаг чанарыг буй болгож, анхаарлыг төвлөрүүлэн хурмастын сэтгэгдлийг төрүүлэх ба Хаант Улсад татагдах шинэ хүчийг бүтээж, дээд оюуны мэдрэмжийг үүсгэдэг болой.”<sup>11</sup>**

1. Ахуйн ертөнцөд хамгийн тансаг сайхан зүйл нь юу вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

2. “Мөргөлийн байдал” гэж ямар утгатай вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

3. Мөргөлийн үр дүнд буй болдог зарим нөхцөлийг бичнэ үү: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

4. Дээрх хэдэн хэсэгт судалсан эшлэлүүдээ эргэн харж, мөргөлийн мөн чанарыг илтгэх таван зүйрлэлийг дор бичнэ үү:

– Мөргөл бол \_\_\_\_\_

– Мөргөл бол \_\_\_\_\_

– Мөргөл бол \_\_\_\_\_

– Мөргөл бол \_\_\_\_\_

– Мөргөл бол \_\_\_\_\_

## 6 ДУГААР ХЭСЭГ

Бахауллагийн дараах үгсийг судалж, утга учрыг нь бясалгана уу:

“Аяа, Миний шадар зарц, өөрийн хүлээж авсан Бурханы шад мөрүүдийг Түүнд ойртогсдын нэгэн адил уянгалуулан, чихэнд чимэгтэй аялгуу нь чиний зүрх сэтгэлийг дүрэлзүүлэн асааж, хүн бүрийн сэтгэлийг татан уяруулаг. Бурханаас ирүүлсэн шад мөрүүдийг хэн тийнхүү өөрийн орон байранд ганцаар цээжээр уншваас Хамгаас хүчит Бурханы сахиулсан тэнгэрүүд тэр хүний амнаас гарсан үгсийн анхилуун үнэрийг зүг бүрд тархааж, сайн санаат хүн бүхний сэтгэлийг догдлуулах болно. Эхэн үедээ тэрбээр үүний нөлөөг анзаарахгүй байж болох боловч түүнд болгоосон энэрэл нигүүлслийн буян эрт орой хэзээ нэгэн цагт оюун сэтгэлд нь нөлөөлөх болно. Ийнхүү Бурханы Үүдэл нээлтийн нууцууд бүх л хүч чадал, мэргэн ухааны Эх үүсвэр болсон Түүний Хүсэл зоригоор айлдагдсан болой.”<sup>12</sup>

1. “Уянгалуулах” гэдэг нь ямар утгатай вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Бурханы шүлэг найргийг бид хэрхэн уянгалуулах ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. “Цээжээр унших” гэдэг нь ямар утгатай вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. “Зүг бүрд тархаах” гэж юу гэсэн утгатай вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
5. Чихэнд чимэгтэй аялгуу өөрсдийн маань сэтгэлд ямар нөлөө үзүүлэх вэ?  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
6. Чихэнд чимэгтэй аялгуу бусад хүмүүсийн сэтгэлд хэрхэн нөлөөлөх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 7 ДУГААР ХЭСЭГ

Бахауллагийн туурвисан нэгэн мөргөлөөс авсан дараах хоёр эшлэлийг цээжлэхийг танд санал болгож байна:

“Бурхан минь, Бурхан минь! Миний юунд найдаж, юу үйлдэж буйг үл хэрэгсэн гагцхүү Тэнгэр диваажин ба газар дэлхийг бүхэлд нь хамарсан Өөрийн хүсэл тааллыг л болгоогтун. Үндэстэн түмэн бүхний Эзэн тэнгэр Таны Хамгийн Дээд Алдарыг барин тангараглая! Би Таны хүссэн бүхнийг хүсэж, хайрласан бүхнийг тань хайрлаж яваа билээ.”<sup>13</sup>

“Танд ойр байхуйн диваажин руу тэмүүлэн Танд ойртон дөхсөн тэдний магтуу дүрсэлж үл дийлэх, Таны үүд хаалганы босгонд хүрэхээр Танд өөрсдийгөө зориулсан тэдний зүрх сэтгэлийн шувууд хүрч үл чадах тийм өндөр байр сууринд Та залардаг билээ. Та бүхий л шинж чанараас дээгүүр гэгээн, бүхий л алдар нэрсээс давуу ариун нандин гэдгийг би гэрчилье. Хамгаас өргөмжит, Хамгаас Гоо жавхлант Танаас өөр Бурхан үгүй.”<sup>14</sup>

## 8 ДУГААР ХЭСЭГ

Абдул-Баха айлдахдаа:

“Бурханы шадар зарцын хувьд Бурханд хандан залбирч, тусламж хүсэх, Түүний дэмжлэг тусыг хичээнгүйлэн гуйх нь туйлын зохилтой. Ийнхүү гуйн залбирах нь Бурханы зарц боолын байр суурь бөгөөд харин Бурхан Эзэн Өөрийн төгс мэргэн ухаанаар, Өөрийн юу хүсэж таалж буйгаа л зарлигдах болно.”<sup>15</sup> гэжээ.

Тэрээр цааш нь тайлбарлахдаа:

“Оюун санаа нь нөлөө үзүүлдэг, тэгвэл мөргөл нь оюун санааны үр нөлөөтэй байдаг. Тиймээс бид Бурхан хариу өгөх болов уу хэмээн найдаж “Бурхан минь, энэ өвчтөнийг эдгээгээч!” гэж мөргөдөг. Хэн мөргөж буй нь тийм чухал гэж үү? Хэрэв чин сэтгэлийн угаас мөргөж буй л бол Бурхан шадар зарц бүрийнхээ мөргөлд хариу өгдөг. Түүний энэрэл бол өргөн уудам, хязгааргүй байдаг. Бурхан бүх шадар зарцынхаа мөргөлд хариу өгдөг. Энэ ургамлын мөргөлд ч хариу өгнө. Ургамал хэрэв “Бурхан минь, надад хур бороогоо хайрлаач!” гэж залбирвал Бурхан энэ залбиралд хариу өгч, ургамал ургана. Бурхан хэнд ч хариу өгдөг.”<sup>16</sup> гэжээ.

Бид мөргөлдөө хэрэгцээ шаардлагыг маань хангаж өгөөч гэж Бурханаас хүсэх нь зүй ёсны хэвийн зүйл юм. Тиймээс бид өөрсдийн болон хайртай дотно хүмүүсийнхээ эрүүл мэндийн төлөө, гэр бүлийнхээ оюун санааны болон материаллаг хөгжил дэвшлийн төлөө, мөн удирдамж чиглэл хүсэн мөргөл уншдаг. Мөн хүн олонд үйлчлэх зам мөрт минь хүч чадал, итгэл үнэмшил, баталгааг хайрлаач хэмээн хүсдэг. Бурханд ийнхүү мөргөн залбирахдаа бид мэдээж өөрсдийн хүсэл сонирхлоо Түүний Хүсэл зоригтой нийцүүлэхэд амьдралын маань зорилго оршино гэдгийг санаж байх нь чухал. Тиймээс бид Түүний Хүсэл зориг биелээсэй хэмээн залбирч, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө өөрийгөө зориулахад бэлэн байх ёстой юм. Хэрэв Абдул-Бахагийн дараах үгсийг цээжилбэл энэ нь бүхий л цаг үед танд баяр жаргал, бат итгэлийн эх үүсвэр болох болно:

“Бурханы зүг нигуур царайгаа хандуулагч та минь ээ! Харцаа Хамгаас Гайхамшигт Түүнээс бусдаас буруулж, гагцхүү Түүний ертөнц рүү хандуул.

Хүссэн бүхнээ зөвхөн Түүнээс хүсэж, хайсан бүхнээ зөвхөн Түүнээс хай. Ганц хараад Тэрээр зуун мянган хүслийг биелүүлж, зэрвэс харах төдийд Тэрээр зуун мянган эдгэшгүй өвчнүүдийг анагааж, ганц дохих төдийд Тэрээр шарх бүрд анагаагч гаврыг талбиж, хоромхон зуур ажих төдийд Тэрээр үй олон зүрх сэтгэлийг уй гашууны дөнгөнөөс чөлөөлж чадна. Тэрээр хүссэн бүхнээ хийнэ, харин бидэнд ямар аврал байна? Тэрээр Өөрийн Хүсэл зоригоор бүхнийг шийдэж, Өөрийн таалалд нийцсэн бүхнийг захирамжилдаг. Тиймээс, чи тэргүүнээ хүлцэнгүйгээр бөхийлгөж, Бүхнийг Өршөөгч Эзэн тэнгэртээ итгэл найдвараа өгөгтүн.”<sup>17</sup>

## 9 ДҮГЭЭР ХЭСЭГ

Энд хүртэл бидний судалсан хэсгүүдэд Бурханд мөргөл залбирлаар дамжуулан хандах нь бидний оюун санааны амьдралын амин чухал шаардлага гэдэг нь тодорхой байсан. Өглөө сэрснийхээ дараа, мөн үдэш орондоо орохынхоо өмнө Бурханд мөргөн залбирна гэдэг хэчнээн онцгой сайхан билээ. Мөргөлд зарцуулах цаг хугацаа, хэдэн мөргөл унших зэрэг нь бидний хэрэгцээ, оюун санааны цангаанаас шалтгаална. Мөн амьдралын янз бүрийн хэрэгцээ шаардлага бүрд зориулан Бахаулла, Баб, Абдул-Бахагийн туурвисан үй олон мөргөлөөс сонгон уншиж болдог. Гэвч үүнээс гадна Бахаулла бидэнд заавал унших гурван мөргөл туурвиж өгсөн байдаг. Шоги Эффенди ингэж хэлжээ:

**“Өдөр бүр заавал унших гурван янзын мөргөл бий. Богино нь нэг бадгаас бүрдэх ба хорин дөрвөн цагт нэг удаа үд дунд үйлдэнэ. “Түүнээс өөр Бурхан үгүй гэдгийг Эзэн Тэнгэр гэрчилнэм” хэмээн эхлэх дунд хэмжээний мөргөлийг өглөө, өдөр, орой гурван удаа үйлдэнэ. Уг мөргөлийг биеэр үйлдэх тодорхой хэдэн үйлдэл, хөдөлгөөн дагалдана. Урт мөргөл нь уг гурван мөргөлийн хамгийн дэлгэрэнгүй нь бөгөөд үүнийг хорин дөрвөн цагт нэг удаа мөргөмөөр санагдсан тэр л цагтаа үйлдэнэ.**

**“Сүсэгтэн хүн уг гурван мөргөлийн алийг нь ч сонгох эрхтэй, гэхдээ аль нэгийг нь заавал сонгож тухайн мөргөлд зориулагдсан зааврынх нь дагуу өдөрт унших үүрэгтэй.”<sup>18</sup>**

Тэрээр цааш нь:

**“Өдөр тутам заавал унших мөргөлүүдэд “Өвчнөөс анагаах мөргөл”, “Ахмаадад илгээсэн Илгээлт” зэрэг бусад тодорхой хэдэн мөргөлүүдийн адил Бахаулла онцгой хүч чадал, ач холбогдол олгосон юм. Тиймээс энэ мөргөлүүдээр дамжуулан Бурхантай илүү ойртон холбогдож, Түүний хууль зарчмуудыг бүрэн дүүрэн даган мөрддөг болохын тулд сүсэгтнүүд эдгээрийн хүч чадлыг ойлгон ухаарч, үл эргэлзэх итгэл бишрэлээр уншваас зохино.”<sup>19</sup>**

Бахауллагийн туурвисан Заавал үйлдэх гурван мөргөлийг хүн ганцаараа байхдаа үйлддэг. Учир нь, өдөр тутмын заавал үйлдэх мөргөлийг тодорхой нэгэн зан үйлийн дагуу бөөнөөрөө үйлддэг тийм нийтийн мөргөлийн үйл Бахай Шүтлэгт байдаггүй. Харин Нас нөгчигсдөд зориулсан мөргөл бол Бахайн хуульд заасны дагуу олноороо байх үедээ

унших ёстой цорын ганц мөргөл юм. Энэ мөргөлийг оршуулгын ёслолын үеэр үйлдэх ба нэг хүн уншиж, бусад нь анир чимээгүй зогсдог.

1. “Заавал үйлдэх” гэж юу гэсэн утгатай вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Өдөр бүр заавал унших хэдэн мөргөлийг Бахаулла туурвисан бэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Өдөр бүр уг гурван мөргөлийг гурвууланг нь үйлдэх хэрэгтэй юу? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Хэрэв заавал унших урт мөргөлийг сонгосон бол өдөрт хэдэн удаа үйлдэх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
5. Дунд хэмжээний мөргөлийг сонгосон бол өдөрт хэдэн удаа үйлдэх вэ? \_\_\_\_\_
6. Богино хэмжээний мөргөлийг өдөрт хэдэн удаа унших вэ? \_\_\_\_\_
7. Онцгой хүч чадал агуулсан зарим мөргөлийг нэрлэнэ үү? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
8. Хэрэв цээжилж амжаагүй бол Заавал үйлдэх богино мөргөлийг цээжилнэ үү:  
**“Бурхан минь ээ! Таныг танин мэдэж, шүтэн биширч яваг хэмээн Та намайг бүтээсэн билээ. Өчүүхэн би хүч мөхөс харин Та хамгаас хүчтэй, би үгээгүй ядуу харин Та хамгаас баян болохыг энэ мөчид би гэрчилнэм.**  
**Танаас өөр Бурхан байхгүй. Та бол Зовсон цагт Аврагч, эгнэгт Дангаар Оршигч билээ.”<sup>20</sup>**
9. Энэ мөргөлд та юуг гэрчлэн хэлдэг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 10 ДУГААР ХЭСЭГ

Заавал үйлдэх мөргөлийн хуулийг даган биелүүлснээрээ хүлээж авах адис ивээл, мөн бусад мөргөлүүдийг ганцаараа байхдаа үйлдсэнээрээ хүртэх оюун санааны тэжээл зэргээс гадна олон ч бай цөөн ч бай хүмүүс оролцсон уулзалт цуглаан дээр унших

мөргөлийг сонордон чагнах үедээ бидний сүнс сэтгэл дэвжин дээшилдэг билээ. Энэ талаар Бахаулла:

**“Та нар туйлын баяр хөөр, найз нөхөрлөлөөр нэгдэн цуглаж, энэрэнгүй Эзэнийхээ нээн туурвисан бадаг найргуудыг уншигтун. Чингэснээр жинхэнэ мэдлэгийн үүд хаалга та нарын дотоодод нээгдэж, сүнс чинь гуйвшгүй бат чанараар хөглөгдөж, зүрх сэтгэл чинь гэрэлтэн цацрах баяр жаргалаар дүүрэхийг мэдрэх болно.”<sup>21</sup>**

Дэлхий даяар найз нөхөд, хөрш айлууд Бурхантай харилцах зорилгоор цугларан явуулдаг мөргөлийн цуглааны тоо мянга мянгаар үржин олширч байгааг дуулж мэдээд бид бүгдэд туйлын их баяр жаргал төрдөг билээ. Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон энэ талаар:

**“Мөргөлийн цуглаан нь ямар ч хүн хөл тавин орж, хурмастын анхилуун үнэрийг үнэрлэж, мөргөлийн тансаг амтыг амсаж, Бүтээлч Үгийг бясалгаж, сүнсний жигүүрээр дүүлэн нисэж, цорын ганц Хайрт Бурхантайгаа харилцах тийм орчин болдог билээ. Ийм уулзалт цуглааны үеэр аяндаа үүсдэг харилцан яриа нь оюун санааг бадрааж, “хүмүүний зүрх сэтгэлийн хот”-ыг нээх үр нөлөөтэй байдаг бөгөөд чухам ийм харилцан ярианы явцад нөхөрлөл ба нийтлэг нэг үйл хэргийн төлөө зорьж буй мэдрэмж бий болдог ажээ.”<sup>22</sup>**

Мөргөл уншихыг хүссэн үедээ юуны өмнө бид бодол санаагаа энэ дэлхийн зүйлсээс чөлөөлөхийн тулд хэсэгхэн хугацаанд нам гүм суун хүлээдэг. Харин мөргөл үйлдэх зуураа бодол санаагаа Бурханд төвлөрүүлнэ. Мөргөлөө уншсаны дараа огцом өөр зүйл рүү шилжилгүй хэсэг зуур чимээгүй хүлээдэг. Цуглааны үеэр бусад хүмүүс мөргөл унших үед ч бид мөн үүнтэй ижил хандлагатай байж, залбирангүй байдлаар тухайн хүний мөргөлийг өөрөө уншиж буй мэт анхааралтай чагнан дагаж сүсэглэнэ.

1. Бурханы бадаг найргуудыг сүсэглэн уншихаар цугласан үедээ бид ямар уур амьсгалтай байх ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Ийнхүү хамтдаа цуглан Бурханы бадаг найргуудыг уншихын үр нөлөө юу байх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Мөргөлийн цуглаан нь ямар ч хүн -даг орчин юм:  
- \_\_\_\_\_ ,  
- \_\_\_\_\_ ,  
- \_\_\_\_\_ ,  
- \_\_\_\_\_ ,

— \_\_\_\_\_ ,  
— \_\_\_\_\_ .

4. Мөргөлийн цуглааны үеэр ямар мэдрэмж бий болдог вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

5. Мөргөлийн цуглааны үеэр аяндаа үүсдэг оюун санааг бадраасан харилцан ярианы үр нөлөө нь юу байдаг вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

6. Ганцаараа буюу уулзалт цуглааны үеэр мөргөл үйлдэхдээ хүндэтгэлтэй хандана гэдэг нь юу гэсэн үг болох талаар тодорхойлж бичнэ үү.

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 11 ДҮГЭЭР ХЭСЭГ

Энэ номын эхний бүлэг Сургаал бичмэлээс өдөр бүр уншиж, утга учрыг нь бясалган тунгаах дадлыг бий болгоход төвлөрч байсан. Харин энд та бүхэн мөргөлийн ач холбогдлын талаар эргэцүүлж, үр дүнд нь өдөр бүр мөргөл үйлдэх дадлыг өөртөө бий болгосон буй. Өмнөх хэсэгт олуулаа, нийгэмлэгээрээ хамтдаа мөргөн сүсэглэхийн ач холбогдлын тухайд та бүхэн анхаарал хандуулсан. Тиймээс энэ хүртэл судалсан бүхэн тань хэрэв хүсвэл таныг үйлчилгээний замнал дахь эхний алхам буюу мөргөлийн цуглаан зохион байгуулахад бэлтгэсэн байгаа билээ.

Анхны алхам болгож та хэд хэдэн мөргөл цээжилж, түүнийгээ цөөн хэдэн найз нартайгаа хуваалцах боломжийг гаргаарай. Түүний хажуугаар, та өөрөө нийгэмлэгтээ явагдаж буй дор хаяж нэг мөргөлийн цуглаанд оролцож, мөргөлийн цуглааны оргилуун дэмжигч нь болж болох юм. Явсаар эцэст нь та өөрөө мөргөлийн цуглаан явуулж, түүндээ найз нөхдөө, гэр бүлийнхэн, айл хөршийнхнөө урьж хамтдаа мөргөл үйлдэн, найз нөхөрлөлийн холбоогоо бэхжүүлэх алхмыг хийгээрэй. Ийм хамтын мөргөлийн цуглаан эхлүүлэхэд эхэндээ хоёр, гурван оролцогчтой байх нь хэвийн зүйл байдаг.

Мөргөлийн цуглааныг ийм тийм байдлаар зохион байгуулна гэсэн нарийн заавар, загвар байдаггүй гэдгийг та төсөөлж байгаа байх. Хамгийн чухал нь, ийм уулзалтын үеэр хэсэг нөхөд цугларан хамтдаа мөргөл уншиж, Сургаал бичмэлээс судалж, сэтгэл санааг бадраасан харилцан яриа өрнөх бөгөөд энэ бүхэн нь илэрхий оюун санаалаг уур амьсгалд

явагдах учиртай юм. Одоо мөргөлийн цуглаан явуулахад дараах зүйлс ямар ач холбогдолтой талаар дүрсэлж бичээрэй.

Бусдыг халуун дулаан, хайрлах сэтгэлээр урьж ирүүлэх: \_\_\_\_\_

---

---

---

Оролцогсдод таатай тухтай орчныг бүрдүүлэх: \_\_\_\_\_

---

---

---

Хүндэтгэлтэй уур амьсгалыг хадгалах: \_\_\_\_\_

---

---

---

Баяр хөөртэй найз нөхөрлөлийг дэмжих: \_\_\_\_\_

---

---

---

Оюун санааны хувьд ач холбогдолтой харилцан яриаг үүсгэх: \_\_\_\_\_

---

---

---



## ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. “Бахауллагийн Сургаалын Дээжис”, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, хоёр дах хэвлэл, 2015 он), XLIII, хуу. 83
2. Бахаулла, in *Trustworthiness: A Compilation of Extracts from the Bahá’í Writings, compiled by the Research Department of the Universal House of Justice* (London: Bahá’í Publishing Trust, 1987), дугаар. 21, хуу. 5.
3. Дэлхийн Бахайн Төв, Хайфа, *The Call of the Divine Beloved: Selected Mystical Works of Bahá’u’lláh* (Haifa: Bahá’í World Centre, 2018), дугаар. 2.43, хуу. 31.
4. Абдул-Баха, Даян дэлхийн энх тайвны тунхаг, *The Promulgation of Universal Peace: Talks Delivered by ‘Abdu’l-Bahá during His Visit to the United States and Canada in 1912* (Wilmette: Bahá’í Publishing, 2012), хуу. 127.
5. Бахаулла, “Эрдэнийн нуугдмал Үгс” (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2013 он), Араб хэлнээс 13, хуу. 10-11
6. Шогги Эффендигийн нэрийн өмнөөс 1935 оны 12 сарын 8-ны өдөр бичсэн захидлаас, “*Prayer and Devotional Life: A Compilation of Extracts from the Writings of Bahá’u’lláh, the Báb, and ‘Abdu’l-Bahá and the Letters of Shoghi Effendi and the Universal House of Justice, compiled by the Research Department of the Universal House of Justice*” номд хэвлэгдсэн (Wilmette: Bahá’í Publishing, 2019), дугаар 71, хуу. 31.
7. Абдул-Бахагийн үгс, Ж.Э.Эссемонт, *Бахаулла ба Шинэ Эрин, Бахай Шүтлэгийн Танилцуулга*, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2014 он)
8. Мөн дээрхийн адил
9. Бахаулла, *Bahá’í Prayers: A Selection of Prayers Revealed by Bahá’u’lláh, the Báb, and ‘Abdu’l-Bahá* (Wilmette: Bahá’í Publishing Trust, 2002, 2017 printing), хуу. 7–8.
10. Мөн дээрхийн адил, хуу. 9
11. Абдул-Баха, *Star of the West* (“Өрнөдийн Од”), VIII боть, дугаар №4 (1917 оны 5-р сарын 17), хуу. 41
12. “Бахауллагийн Сургаалын Дээжис”, (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, Хоёр дах хэвлэл, 2015 он), CXXXVI, хуу. 237, мөн “Бахайн мөргөлийн түүвэр” (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2013 он), хуу. iii
13. Бахаулла, “Бахайн мөргөлийн түүвэр” (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2013 он), хуу. 16
14. Мөн дээрхийн адил, хуу. 20

- 
15. Абдул-Баха, *“Prayer and Devotional Life”* (Мөргөл ба Бясалгалын Амьдрал), дугаар 24, хуу. 7
  16. Абдул-Баха, 1912 оны 8 сарын 5-нд өгсөн ярианаас, *The Promulgation of Universal Peace* (Даян дэлхийн энх тайвны тунхаг), хуу. 345
  17. Абдул-Баха, *Selections from the Writings of Abdul-Baha* (“Абдул-Бахагийн Сургаалын түүвэр”) (Wilmette: Bahá’í Publishing, 2010, 2015 printing), дугаар. 22.1, хуу. 75–76.
  18. Шоги Эффендийн нэрийн өмнөөс 1936 оны 1 сарын 10-ны өдөр бичсэн захидлаас, *“Prayer and Devotional Life”* (Мөргөл ба Бясалгалын Амьдрал), дугаар 61, хуу. 25
  19. Шоги Эффендийн нэрийн өмнөөс 1936 оны 1 сарын 10-ны өдөр бичсэн захидлаас, *“Бахайн Мөргөлүүд”* номд эш татсан, хуу. 301
  20. Бахаулла, *“Бахайн Мөргөлүүд”*, хуу. 4
  21. Бахаулла, *“Prayer and Devotional Life”* (Мөргөл ба Бясалгалын Амьдрал), дугаар 68, хуу. 29
  22. 2015 оны 12 сарын 29-ний өдрийн захидлаас, *Framework for Action: Selected Messages of the Universal House of Justice and Supplementary Material, 2006–2016* (West Palm Beach: Palabra Publications, 2017) номд хэвлэгдсэн, дугаар. 35.49, хуу. 232.



# Амьдрал ба үхэл

## Зорилго

Амьдрал гэдэг бол зөвхөн энэ дэлхий дээрх элдэв хувирал өөрчлөлт, тохиолдлуудаас л бүрддэг бус харин хүний оюун сэтгэл буюу сүнсний хөгжил дэвшилд хүрэхэд түүний утга учир нь оршдог болохыг ойлгох



## 1 ДҮГЭЭР ХЭСЭГ

Хүний оюун сэтгэл буюу сүнс нь матери болон биет орчлонгоос ангид оршино. Өөрийн нэгэн айлдвартаа Абдул-Баха ийнхүү тайлбарласан байдаг. Үүнд:

**“Эдгээр материаллаг биет нь эгэл хэсэг атомаас бүрддэг агаад атомууд бутарч эхлэнгүүт задрал явагдаж бидний хэлдгээр үхэл ирдэг....**

**Харин оюун санаа, сүнсний хувьд бол өөр юм. Сүнс бол олон янзын элементийн бүрдэл биш, бас олон атомын нэгдэл ч биш, харин хуваагдашгүй нэгэн цул мөн чанар тул үүрдийн үүрд оршино. Сүнс нь биет орчлонгийн дэг жаягаас огт тусдаа ангид зүйл бөгөөд үхэшгүй мөнх билээ!”<sup>1</sup>**

1. “Бүрдэх” гэдэг нь ямар утгатай үг вэ? \_\_\_\_\_
2. Хүний сүнс нь материаллаг биетийн адил олон янзын элементээс бүрддэг үү?  
\_\_\_\_\_
3. Хүний сүнс нь биет зүйл мөн үү? \_\_\_\_\_

## 2 ДУГААР ХЭСЭГ

Асран тэтгэгч Шоги Эффендигийн нэрийн өмнөөс бичсэн нэгэн захидалд “хүний сүнс үр тогтох тэр үед буй болдог”<sup>2</sup> хэмээсэн байдаг. Харин “үр хөврөл үүсэх” гэдэг нь яг юу гэсэн утгатай болох талаарх асуултад өгсөн хариундаа Даян Дэлхийн Шударга Ёсны Ордон ийнхүү тэмдэглэсэн байна. Үүнд:

**“Бахайн Сургаал бичвэрээс “үр тогтох” хэмээх биологийн мөчийг болон уг үзэгдлийн мөн чанарыг нарийн тодорхойлсон тайлбар олдоогүй болно. Анагаах ухаанд ч гэсэн энэхүү нэр томъёог төдийлөн нарийн тодорхойлсон байдаггүй бололтой. Үнэндээ, нэг талаас “үр тогтолт” гэдэг нь үр барьцалдах тэр мөчтэй давхацдаг хэмээх ойлголт байдаг бол нөгөө талаас энэ нь үр барьцалдан үүсэж, дараа нь эхийн хэвлийд наалдан тогтсоноор жирэмслэлт эхлэх үеийг хэлнэ хэмээн ойлгодог ажээ. Тиймээс сүнс нь материаллаг биеийн эд эстэй яг хэдийнээс холбогдож эхэлдгийг нарийн мэдэх боломжгүй байж магадгүй бөгөөд иймэрхүү асуулт нь оюун санааны ертөнцөд хамааралтайн дээр хүний сүнсний өөрийнх нь мөн чанартай холбоотой учраас хүний ухаан сэтгэхүй, судалгаагаар тайлах боломжгүй болов уу.”<sup>3</sup>**

1. Хүний сүнс хэдийд үүсдэг вэ? \_\_\_\_\_
2. “Үр тогтолт” гэсэн нэр томъёо нь биологийн нарийн цаг мөчийг илтгэдэг үү?  
\_\_\_\_\_

### 3 ДУГААР ХЭСЭГ

Хүний сүнс ба бие махбод хоёрын хоорондын уялдаа холбоо нь биет шинж чанартай биш юм. Сүнс бие махбодын дотор орох эсвэл бие махбодоос гарна гэж байхгүй бөгөөд ямар нэгэн биет орон зайг эзэлдэггүй. Бие махбодтой холбогдох түүний холбоо нь гэрэл ба түүнийг тусгасан толь хоёрын хоорондын холбоотой адил юм. Толинд туссан гэрэл нь толин дотор оршдоггүй шүү дээ. Үүний адилаар, сүнс нь бие махбод дотор оршдоггүй байна. Абдул-Бахагийн айлдсанаар:

**“Ухамсарт сүнс буюу хүний оюун санаа нь бие махбодтой нэгдэх замаар бие махбодоор тэтгүүлж оршдоггүй, өөрөөр хэлбэл, сүнс нь бие махбод дотор ордоггүй юм. Учир нь, нэгдэх, орох гэдэг нь бодит биет зүйлсийн шинж чанар болох агаад ухамсарт сүнс нь ийм ойлголтоос огт тусдаа нандин зүйл билээ. Сүнс анхнаасаа бие махбодод нэвтрэн ороогүй тул түүнээс салан холдох тэр үедээ өөр орогнол хайх шаардлагагүй юм. Үгүй ээ, сүнс бол бие махбодтой яг л энэ дэнлүү толь хоёр шиг холбоотой. Толь цэвэр тунгалаг бол дэнлүүний гэрэл түүнд тусна, харин толь хагарсан юм уу тоос тортогт дарагдсан байх юм бол гэрлийн туяа халхлагдсан хэвээр байна.”<sup>4</sup>**

1. Доорх өгүүлбэрт буй хоосон зайг нөхөж бичнэ үү. Үүнд:

- a. Ухамсарт сүнс буюу \_\_\_\_\_ нь бие махбодтой нэгдэх замаар бие махбодоор тэтгүүлж оршдоггүй, өөрөөр хэлбэл, сүнс нь \_\_\_\_\_.
- b. \_\_\_\_\_ буюу хүний оюун санаа нь бие махбод дотор ордоггүй. Учир нь, нэгдэх, орох гэдэг нь \_\_\_\_\_ болох агаад ухамсарт сүнс нь \_\_\_\_\_.
- c. Сүнс анхнаасаа \_\_\_\_\_ тул түүнээс салан холдох тэр үедээ \_\_\_\_\_ юм.
- d. Сүнс бол бие махбодтой яг л \_\_\_\_\_ шиг холбоотой.
- e. Толь цэвэр тунгалаг бол \_\_\_\_\_ түүнд тусна.
- f. Толь хагарсан юм уу тоос тортогт дарагдсан байх юм бол гэрлийн туяа \_\_\_\_\_ байна.

2. Энэ хүртэл олж авсан ойлголт дээрээ тулгуурлан дараахын аль нь үнэн болохыг тодорхойлно уу. Үүнд:

\_\_\_\_\_ Сүнс нь биет орчлонд харьяалагддаггүй.

\_\_\_\_\_ Сүнс нь бие махбод дотор оршдог.

- \_\_\_\_\_ Бие махбод нь сүнсний эзэн нь юм.
- \_\_\_\_\_ Сүнс бол үхэшгүй мөнх юм.
- \_\_\_\_\_ Сүнс үр хөврөлтэй холбогдсоноор хүн үүсэн буй болдог.
- \_\_\_\_\_ Хүн энэ дэлхийд мэндэлснээр амьдралаа эхэлдэг.
- \_\_\_\_\_ Хүний материаллаг оршин тогтнол үхлийн дараа ч үргэлжилсэн хэвээр байна.
- \_\_\_\_\_ Бидэнд өдөр бүр тохиолддог зүйлсээс амьдрал маань бүрдэж байдаг.

3. Гэрэл толь хоёрын зүйрлэлийг ашиглан хүний сүнс ба бие махбод хоёрын харилцааг тайлбарлана уу: \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_

#### 4 ДҮГЭЭР ХЭСЭГ

Сүнс ба бие махбодын хооронд туйлын онцгой уялдаа холбоо байдаг бөгөөд ингэж байж хүн болдог байна. Энэхүү харилцаа нь энэ насны амьдралын хугацаанд л үргэлжилнэ. Тэгээд тус харилцаа дуусангуут сүнс, бие махбод нь тус тус хаанаас үүсэлтэй түүн лүүгээ буцдаг байна. Бие махбод газар шороондоо шингэж, харин сүнс нь Бурханы оюун санааны ертөнц рүү буцаж мөнхөд хөгжин урагшлах аян замаа үргэлжлүүлдэг. Абдул-Баха ийнхүү айлджээ:

**“Хүний оюун санаа нь эхлэлтэй боловч эцэс төгсгөлгүй бөгөөд мөнхийн мөнхөд оршдог.”<sup>5</sup>**

Өөр нэгэн айлдвартаа Тэрээр ийнхүү дэлгэрүүлэн тайлбарласан байдаг:

**“Оюун санаанд бие махбод хэрэггүй бол бие махбодод оюун санаа зайлшгүй хэрэгтэй, эс бөгөөс оршин тогтнож үл чадна. Сүнс нь бие махбодгүй оршиж чадна, харин сүнсгүй бол бие махбод үхэж үрэгдэнэ.”<sup>6</sup>**

Асран тэтгэгч ийнхүү тайлбарлажээ:

**“Хүний сүнсний тухайд гэвэл: Бахайн Сургаалыг үзвэл хүний сүнс нь үр хөврөл бүрэлдэн буй болох тэр үед оршиж эхлэх бөгөөд бие махбодоос салсныхаа дараа оршихуйн төгсгөлгүй олон үе шатыг даван хөгжин дэвшсээр байдаг байна. Тиймээс сүнсний хөгжил хязгааргүй юм.”<sup>7</sup>**

1. Дээрх эшлэлүүдийг оюун ухаандаа тунгаах зуураа дараах асуултад хариулна уу. Үүнд:

- a. Бие махбодод сүнс хэрэгтэй юу? \_\_\_\_\_
- b. Сүнсэнд бие махбод хэрэгтэй юу? \_\_\_\_\_
- c. Үхэл ирэхэд бие махбод ба сүнсний хоорондын харилцаа нь яадаг вэ? \_\_\_\_\_
- d. Үхлийн дараа сүнс яадаг вэ? \_\_\_\_\_
- e. Сүнс хэр удаан үргэлжлэн хөгжсөөр байдаг вэ? \_\_\_\_\_
- f. Амьдрал хэзээ дуусдаг вэ? \_\_\_\_\_

2. Дараахын аль нь дээрх хэсгүүдэд бидний судалсан зүйлстэй утга нийцэж байна вэ?

- \_\_\_\_\_ Үхэл бол шийтгэл юм.
- \_\_\_\_\_ Бие махбод ба сүнсний хоорондын харилцаа зөвхөн зуурдын энэ амьдралын хугацаанд л үргэлжилдэг.
- \_\_\_\_\_ Бие махбод нь мөнхөд хөгжин дэвших чадвартай.
- \_\_\_\_\_ Сүнс үүрд хөгжин дэвшдэг.
- \_\_\_\_\_ Үхэл бол амьдралын төгсгөл юм.
- \_\_\_\_\_ Бидний бие махбод амилан босож эцсийн шүүлтэд орох өдөр ирэх болно.
- \_\_\_\_\_ Үхлийн дараа сүнс маань өмнөхөөсөө илүү эрх чөлөөтэй болно.
- \_\_\_\_\_ Амьдрал үхлээр дуусдаг.
- \_\_\_\_\_ Бид үхлээс айх хэрэгтэй.
- \_\_\_\_\_ Сүнсэнд хоол хүнс, хувцас хунар, амралт, зугаа цэнгэл хэрэгтэй.
- \_\_\_\_\_ Бие махбод маань ядарч туйлдахад сүнс маань бас эцэн туйлдаг.
- \_\_\_\_\_ Биеийн өвчин зовлон, сул дорой байдал сүнсэнд нөлөөлөхгүй.
- \_\_\_\_\_ Үхлийн дараа ч хүнд материаллаг хэрэгцээ байсаар л байдаг.

## 5 ДУГААР ХЭСЭГ

Хүний сүнс нь биет орон зайг эзлэхгүйгээс гадна материаллаг биетүүдийн адил байгалийн хуулийг дагадаггүй гэдгийг бид олж мэдлээ. Сүнс нь бие махбодоор



дамжуулан энэ ертөнцөд нөлөө үзүүлдэг, гэхдээ ганцхан бие махбодоор л өөрийн хүч нөлөөг мэдрүүлэх биш ажээ. Бахаулла ийнхүү айлдсан байна:

**“Хүний сүнс бол гарах, буцаж орох мэтийн аливаа ойлголтоос огт ангид, хань хамаагүй зүйл гэдгийг Би үнэнхүү айлдаж байна. Сүнс нь тогтвортой атлаа чөлөөтэй элэн халина, сүнс нь хөдөлгөөнтэй боловч нам гүм оршино.”<sup>8</sup>**

Мөн Абдул-Баха ингэж бидэнд хэлсэн байна:

**“Хүний сүнс нь өөрийн хүч нөлөөгөө мэдрүүлж, аливааг хүлээн авч ухамсарлах хоёр янзаар явагддаг гэдгийг ойлгож авагтун. Өөрөөр хэлбэл, хүний сүнс хоёр аргаар өөрийгөө илэрхийлж, эргээд юмсыг ойлгон мэддэрч. Нэг нь биеийн эрхтэн, зэмсгээр дамжуулан тухайлбал, нүдээр дамжуулан харж, чихээр дамжуулан сонсож, хэлээр дамжуулан ярьдаг...”**

**Харин сүнсний хүч нөлөө, үйлдлээ илэрхийлэх нөгөө арга нь бол бие махбод, эд эрхтний тусламжгүйгээр явагддаг.”<sup>9</sup>**

1. Дараах өгүүлбэр дэх хоосон зайг нөхөж бичнэ үү:
  - a. Хүний сүнс бол \_\_\_\_\_, \_\_\_\_\_ мэтийн аливаа ойлголтоос огт ангид оршдог.
  - b. Сүнс нь \_\_\_\_\_ атлаа \_\_\_\_\_.
  - c. Сүнс нь \_\_\_\_\_ боловч \_\_\_\_\_ оршино.
2. Хүний сүнс энэ ертөнцөд аливааг ойлгон мэдэрч, хүч нөлөөгөө мэдрүүлдэг тэрхүү хоёр аргыг энд тайлбарлана уу: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Сүнс нь бие махбод, эд эрхтний тусламжгүйгээр хүч нөлөө, үйлдлээ илэрхийлдгийн жишээг гаргана уу: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## **6 ДУГААР ХЭСЭГ**

Өмнөх хэсгүүдэд хийсэн хэлэлцүүлгээ санангаа одоо Бахауллагийн Сургаал бичвэрээс авсан дараах эшлэлийг уншина уу:

“Хүний сүнс нь биеийн эсвэл оюун ухааны аливаа сул дорой байдлаас огт хамааралгүй агаад түүнээс хавьгүй өндөр байр суурьтай гэдгийг мэдэгтүн. Өвчтэй хүн зовуурьтай, сул дорой болдог нь түүний сүнс ба бие махбодын хооронд саад тотгор үүссэнтэй холбоотой, учир нь хүний сүнс бол бие махбодын өвчин эмгэгт үл өртөнө. Дэнлүүний гэрлийг бодож үзэгтүн. Хөндлөнгөөс ямар нэг биет түүний гэрлийг халхлан саад болж чадах хэдий ч гэрэл өөрөө эрч хүч нь үл бууран гэрэлтсээр л байна. Үүний нэгэн адил, хүний биеийг нэрвэсэн өвчин эмгэг бүр нь хүний сүнс бүхий л хүч чадлаа илэрхийлэн харуулахад нь саад болдог байна. Харин бие махбодоосоо салах цагт сүнс газар дэлхийн ямар ч хүч үл дүйцэх тийм түвшинд дэвшин дээшилж, тийм их эрч хүчийг тодруулан харуулна. Ариун цагаан, боловсрон гэгээрсэн, ариуссан сүнс бүр туйлын их хүч чадлыг эзэмшиж, туйлын их баяр жаргалыг эдлэх болмуй.”<sup>10</sup>

1. Хүний сүнс бие махбодын юм уу оюун ухааны сул дорой байдлаас огт хамааралгүй ангид оршдог талаар, мөн бие махбодоос салсны дараа сүнс нь ямар байдалтай болдог талаар өөрийн үгээр тайлбарлан бичнэ үү:

---

---

---

---

---

---

---

---

2. Бие махбод маань үхэж мөхсөний дараа бид өөрсдийн хувь хүний шинж чанараа авч үлдэх болов уу? \_\_\_\_\_

## 7 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла хэлэхдээ:

“Харин одоо хүний сүнс болон үхлийн дараах түүний байдлын талаар таны асуултыг болгооё. Хүний бие махбодоос салсныхаа дараа ямар ч эрин үеийн хувьсгал, энэ дэлхийн ямар ч өөрчлөлт, элдэв тохиолдлуудын нөлөөнд үл автан хувирахааргүй тийм нөхцөл байдалд орших сүнс нь Бурханы ахуйд очих хүртлээ зогсолтгүй хөгжин дэвшдэг хэмээх үнэнийг мэдтүгэй. Бурханы Хаант улс, Түүний эзэрхэл, Түүний ноёрхол ба хүч чадал оршоор байсан цагт сүнс оршоор байх болно. Сүнс нь Бурханы шинж тэмдэг болон Түүний шинж чанарыг харуулж, Түүний хайр халамж, буян хишгийг илэрхийлэх амой.”<sup>11</sup> гэжээ.

1. Бие махбодоос салсныхаа дараа хүний сүнс хэр удаан хугацаанд хөгжин дэвшдэг вэ? \_\_\_\_\_
2. Сүнс нь Бурханы ахуйд очих хүртлээ ямар нөхцөл байдалд мөнхийн аян замаа туулдаг вэ? \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_
3. Ийм нөхцөл байдалд сүнсний харуулах зарим нэг шинж чанар, шинж тэмдгийг нэрлэнэ үү. \_\_\_\_\_  
 \_\_\_\_\_
4. Энэ хүртэл олж авсан ойлголт дээрээ тулгуурлан дараахын аль нь үнэн болохыг тодорхойлно уу:
  - \_\_\_\_\_ Бурханы Хаант улс мөнхөд оршино.
  - \_\_\_\_\_ Хүний сүнс нь Бурханы шинж чанаруудыг илэрхийлэн харуулах нөөц чадавхтай
  - \_\_\_\_\_ Нас нөгчигсдийн төлөө бидний уншсан мөргөл сүнснийх нь цаашдын хөгжил дэвшилд нөлөө үзүүлдэггүй.
  - \_\_\_\_\_ Хүний сүнс хэзээд оршсон хэвээр байдаг.

## 8 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла айлдсан нь:

**“Сонсох чих бүр хэрэв цэвэр ариун, бузар буртаггүй байх аваас “Үнэнхүү бид бол Бурханых, Түүндээ бид эргэн очно” гэсэн ариун үгсийг шивнэх дуу хоолойг цаг ямагт, зүг бүрээс лавтайяа сонсоно гэдгийг мэдтүгэй. Хүний биет үхэл ба эргэн очихын оньсого нууцууд тайлагдаагүй бөгөөд одоо ч тодорхойгүй хэвээр байна....**

**Үхэл бол бат итгэлт сүсэгтэн бүрд үнэндээ амьдрал хэмээх бумбыг бэлэглэдэг. Энэ нь баяр жаргалыг заяаж, хөөр баяслыг авчирдаг. Мөн өнө мөнхийн амьдралын хишиг хайрладаг.**

**Цорын ганц үнэн Бурханыг (Түүний алдар бадартугай) танин мэдэхэд утга учир нь орших энэ газар дэлхийн амьдралын үр жимснээс амталсан хүмүүсийн амьдрал үүнээс хойш ямар байхыг Бид дүрсэлж үл дийлнэ. Үүнийг гагцхүү бүх хорвоо ертөнцүүдийн Эзэн тэнгэр Бурхан л мэднэ”<sup>12</sup>**

**“Аяа, Дээд тэнгэрийн үр! Би чамд зориулан үхлийг баяр жаргалын элч болгосон байтал юунд чи уй гашууд автана вэ? Чам дээр сүрлэг сайхнаа**



чадавх, үнэ цэнээ хөгжүүлдэг. Энэ орчлонд амьдрахад хэрэгцээтэй чадвар чадавхыг тэр ертөнцөд байхдаа олж авдаг. Энэ ертөнцөд бидэнд хараа хэрэгтэй тул эхийн хэвлийд байхдаа нүдтэй болно. Энэ ертөнцөд сонсох чих хэрэгтэй тул эхийн хэвлийд байхдаа чихтэй болж авна. Энэ ертөнцөд шаардлагатай бүх хүч чадавхыг тэрээр эхийн хэвлийн ертөнцөд байхдаа олж авдаг. Тэр ертөнцөд байхдаа тэрээр энэ орчлонгийн амьдралд бэлтгэгдэх бөгөөд энэ ертөнцөд мэндлэн хөл тавих үедээ энд хэрэгтэй бүхий л хэрэгцээтэй хүч чадавхыг хэдийнээ эзэмшиж, энэ амьдралд түүнд шаардлагатай бүхий л гар хөл, мөч, эрхтнээ өмнөх ертөнцөд байхдаа олж авсан байдаг. Тийм учраас энэ ертөнцөд амьдрах хугацаандаа хүн дараагийн амьдралдаа бэлтгэх ёстой. Бурханы Хаант улсын ертөнцөд шаардлагатай бүхнээ хүн энэ ертөнцөд л базааж авах хэрэгтэй. Эхийн хэвлийд байхдаа энэ ертөнцийн амьдралд бэлтгэн, бүхий л хүч чадлыг эзэмшсэн шигээр Хаант улсын ертөнцөд хэрэгцээтэй бүхнээ, өөрөөр хэлбэл бүхий л тэнгэрлэг хүч чадлыг энэ ертөнцөд байхдаа хөгжүүлэх ёстой юм.”<sup>14</sup>

1. Дараах нь үнэн эсэхийг тодорхойлно уу:

\_\_\_\_\_ Энэ ертөнцөд шаардлагатай бүхий л хүч чадлыг бид эхийн хэвлийд байхдаа олж авдаг.

\_\_\_\_\_ Хойд насны амьдралдаа бэлтгэх шаардлага байхгүй.

\_\_\_\_\_ Бурханы Оронд шаардлагатай бүхнийг бид энд байхдаа базааж авах хэрэгтэй.

\_\_\_\_\_ Дараагийн амьдралд хэрэгтэй чадвар чадавхыг эзэмших нь энэ амьдралын зорилго мөн.

\_\_\_\_\_ Хүн нас нөгчиж, тэнгэрлэг Хаант улсад очсоноор жинхэнэ амьдрал эхэлдэг.

\_\_\_\_\_ Жинхэнэ амьдрал бол энэ орчлонд эхэлж, бие махбодын үхлийн дараа үргэлжилдэг.

2. Эхийн хэвлийд байхдаа олж авдаг зарим чадвар чадавх нь юу вэ?

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

3. Үхлийн дараах амьдралдаа зориулж ямар ямар авьяас чадавхыг энэ амьдралдаа базааж авах хэрэгтэй вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

## 10 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү тунхаглажээ:

“Энэ Өдөр хүмүүний хүлээх амин чухал үүрэг нь Бурханаас ундруулсан өгөөмөр буяны далайгаас өөрт нь ногдсон хувь хишгээ хүртэх явдал юм. Тиймээс хэн ч савныхаа их бага хэмжээг үл харгалзаг. Зарим хүний хувь алга дүүрэн байхад зарим хүнийх аяга дүүрэн, харин зарим хүнийх магад торх дүүрэн ч хэмжигдэж болох.”<sup>15</sup>

1. Дээрх эшлэл дээр тулгуурлан дараах асуултад хариулна уу:

a. Энэ Өдөр хүн бүрийн үүрэг юунд орших вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

b. Бурханаас хүлээж авсан зарим адис хишиг тань юу вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

c. Дээрх эшлэлд “сав” гэдэг нь ямар утгыг илэрхийлж байна вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

d. Яагаад бид өөрт ногдсон савныхаа “их бага хэмжээг” харгалзах ёсгүй вэ?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

e. д. Бурханаас хайрласан буян хишгийн далайгаас хувь хишгээ хүртэхэд маань саад болох зарим зүйлс нь юу вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

2. Дараахын аль нь үнэн бэ?

\_\_\_\_\_ Бидэнд заяасан нөөц чадавхын “их бага хэмжээ” нь хэр зэрэг ухаантай болохыг маань тодорхойлж байгаа юм.

\_\_\_\_\_ Бурханд үйлчлэхийн тулд бид сул дорой байдлаа мартаж, бүхий л итгэл найдвараа Түүнд даатгах хэрэгтэй.

\_\_\_\_\_ Бурханаас бидэнд заяасан нөөц чадавхаа энэ дэлхийд хөгжүүлэхгүй бол дараагийн ертөнцөд очиход сүнс маань сул дорой байх болно.

## 11 ДҮГЭЭР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү айлджээ:

“Сүнсний мөн чанарын тухай та Надаас асуулаа. Сүнс бол Бурханы бэлгэ тэмдэг бөгөөд мөн чанарыг нь хамгийн мэргэн ухаантан хүмүүс ч ойлгож чадаагүй, нууц суу билгийг нь хэчнээн ч хурц оюун ухаантан тайлна гэж найдахааргүй тэнгэрлэг эрдэнэ юм. Орчлонд бүтээгдсэн бүхий л зүйлс дундаас чухамхүү сүнс л хамгийн анх Бүтээгчийнхээ төгс билгийг тунхаглан, Түүний алдрыг хүлээн зөвшөөрч, Түүний үнэнээс бат зуурч, Түүний өмнө бишрэл дүүрэн сөгдөн мэхийдэг бөлгөө.”<sup>16</sup>

1. Дараах өгүүлбэр дэх хоосон зайг нөхөж бичнэ үү:
  - a. Сүнс бол Бурханы \_\_\_\_\_.
  - b. Сүнс бол \_\_\_\_\_ бөгөөд \_\_\_\_\_ нь хамгийн мэргэн ухаантан хүмүүс ч ойлгож чадаагүй, \_\_\_\_\_ нь хэчнээн ч хурц оюун ухаантан \_\_\_\_\_ гэж найдахааргүй \_\_\_\_\_ юм.
  - c. чухамхүү сүнс л \_\_\_\_\_ тунхагладаг.
  - d. Чухамхүү сүнс л хамгийн анх Бурханы алдрыг \_\_\_\_\_.
  - e. Чухамхүү сүнс л хамгийн анх Бурханы үнэнээс \_\_\_\_\_.
  - f. Чухамхүү сүнс л хамгийн анх Бурханы өмнө бишрэл дүүрэн \_\_\_\_\_.

2. Дараахын аль нь үнэн бэ?

- \_\_\_\_\_ “Тайлна” гэдэг нь учрыг нь олж мэдэх гэсэн үг.
- \_\_\_\_\_ Орчлонд бүтээгдсэн бүхий л зүйлсээс хүний тархи л Бурханыг хамгийн анх танин мэддэг.
- \_\_\_\_\_ “Хурц” гэдэг нь айхтар ухаалаг гэсэн үг.
- \_\_\_\_\_ Эрдэм номтой хүн сүнсний нууцлаг мөн чанарыг мэднэ.
- \_\_\_\_\_ Зөвхөн агуу гүн ухаантнууд л Бурханы төгс билгийг тунхаглаж чадна.
- \_\_\_\_\_ Сүнсний мөн чанарыг хэзээ ч ойлгож чадахгүй юм чинь бид хүний сүнс, оюун сэтгэлийн тухай бодох шаардлагагүй.

## 12 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү айлджээ:

“Та нар яг л хүчирхэг жигүүрийнхээ хүчээр бат итгэлтэйгээр баяр жаргал дүүрэн тэнгэр диваажингийн хязгааргүй орчинд дүүлж байснаа цангаага гаргахын тулд дор орших газар дэлхийн ус ба шавар шороо руу тэмүүлэн буусан боловч ээдрээт дур хүслийнхээ урхинд баригдан, анх ирсэн ертөнц рүүгээ буцаад нисэх хүч чадалгүй болсон шувуу лугаа адил болой. Шавар шавхайнд бохирдсон жигүүрээ сэгерэх чадалгүй болсон тэр шувуу хэдийгээр тэнгэрийн оршин суугч боловч эдүгээ газар шороон дээр орогнох байраа хайхаас өөр аргагүйд хүрсэн байна. Тиймээс, шадар зарц нар минь, Миний тэнгэрлэг мэдлэгийн тэнгэрт нисэн дүүлэхэд чинь юу ч саад болохгүйн тулд өөрийн жигүүрээ мунхаг тэнэг зан, хөнгөмсөг дур хүслийнхээ шавхайнд үл бохирдуулж, агаа жөтөө, үзэн ядалтын тоос шороонд бүү бузартуулагтун.”<sup>17</sup>

1. Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:
  - a. Бахауллагийн энэ сургаалд өгүүлсэн шувуу бол хүний \_\_\_\_\_ юм.
  - b. Энэ шувуу бол \_\_\_\_\_ оршин суугч билээ.
  - c. Шавар шавхайнд жигүүр нь бохирдсон бол шувуу \_\_\_\_\_ дээр гэрээ засахаас өөр аргагүйд хүрдэг.
  
2. Одоо дараах асуултад хариулна уу:
  - a. Сүнсний “жигүүр” хэрхэн “бохирддог” вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
  - b. “Ус ба шавар шороо”-ны адил бидний сүнсний жигүүрийг бохирдуулж дарамт болдог зарим зүйлс нь юу вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
  - c. Тэнгэрлэг мэдлэгийн тэнгэрт дахин нисэн дүүлэхэд бидэнд юу саад болдог вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
  - d. Хүний сүнс нь тэнгэр дэх гэрээ яагаад газрын гэрээр сольдог юм бол? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_



3. Дараах өгүүлбэрүүдийн аль нь үнэн болохыг тодорхойлно уу:

\_\_\_\_\_ Газар дэлхийн зүйлсэд уягдах нь оюун санааны хөгжилд маань саад болдог.

\_\_\_\_\_ Бид мунхаг тэнэг зан, хөнгөмсөг дур хүсэлдээ баригдахаараа тэнгэрлэг мэдлэгийн тэнгэрт дүүлэн нисэж чаддаггүй.

\_\_\_\_\_ Атаа жетөө, үзэн ядах сэтгэл нь хүнд байгалиас заяасан зан төрх бөгөөд хүний сүнсэнд дарамт болдоггүй.

\_\_\_\_\_ Газар дэлхийн эд зүйлсийг огоорч чадсанаар бид тэнгэрийн хязгааргүй орчинд дүүлэн нисэхэд маань саад болж хүндрүүлдэг тэдгээр зүйлсийг таягдан хаяж чадна.

\_\_\_\_\_ Сүнсний гэр орон бол энэ газар дэлхийд байдаг.

### 13 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү айлджээ:

“Бурхан дэлхий ертөнц болон түүнд амьдарч буй, оршиж буй бүхнийг хамтад нь бүтээн цогцлуулахдаа Түүнийг танин мэдэж, Түүнийг хайрлах онцлог чадвар болон чадавхыг Өөрийн хязгааргүй, хүчирхэг Хүсэл зоригийн шууд үйлчлэлээр дамжуулан чухамхүү хүмүүнд л олгожээ. Энэ чадавхыг чухам түүнийг бүтээсний үндсэн шалтгаан бөгөөд анхдагч зорилго хэмээн үзэх ёстой юм... Бүтээгдсэн юмсын нэг бүрийн дотоод мөн чанарт Тэрээр Өөрийн нэгэн алдар нэрийн гэрэл гэгээг тусгаж, Өөрийн нэгэн шинж чанарын алдрыг хүртээсэн юм. Харин хүмүүний бодит мөн чанарт Тэрээр Өөрийн бүхий л алдар нэр, шинж чанарын гэрлийг тусгасан бөгөөд түүнийг Өөрийн тольт тусгал байхаар бүтээжээ. Хамаг амьтдаас гагцхүү хүнийг л онцгойлон үзэж ийм агуу их ивээл, ийм ашид мөнхийн хишгийг хүртэх тавиланг заяасан юм.”<sup>18</sup>

1. Хоосон зайг нөхөж бичнэ үү.

a. Бурхан \_\_\_\_\_  
\_\_\_\_\_, \_\_\_\_\_  
\_\_\_\_\_, \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ онцлог чадвар болон чадавхыг чухамхүү  
хүмүүнд л олгожээ.

b. Бүтээгдсэн юмсын \_\_\_\_\_  
дотоод мөн чанарт Бурхан \_\_\_\_\_-н гэрэл  
гэгээг тусгаж, \_\_\_\_\_-г хүртээсэн юм.

с. Хүний бодит мөн чанарт Тэрээр Өөрийн \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ гэрлийг тусгасан бөгөөд  
хүнийг \_\_\_\_\_ тольт тусгал байхаар бүтээжээ.

2. Одоо дараах асуултад хариулна уу:

a. Бурханы зарим шинж чанараас нэрлэнэ үү: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

b. Хүний сүнс тусган харуулж чадах Бурханы зарим нэг шинж чанар нь юу вэ?

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

c. Уг шинж чанаруудыг хэрхэн илэрхийлэн харуулж болох вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

d. Ямар онцгой ивээл гагцхүү хүнд заяагдсан вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

3. Дараахын аль нь үнэн бэ?

\_\_\_\_\_ Бүтээгдсэн бусад зүйлсээс хүн ялгаатай биш.

\_\_\_\_\_ Бурханыг танин мэдэх, Түүнийг хайрлах чадавх нь бүхий л байгаль дэлхий бүтээгдсэний үндсэн шалтгаан бөгөөд анхдагч зорилго мөн.

\_\_\_\_\_ Бүтээгдсэн зүйл бүрийн мөн чанар нь Бурханы аль нэгэн шинж чанарыг хүртэн илэрхийлэн харуулахад оршино.

\_\_\_\_\_ Хүний сүнс бол Бурханы бүхий л шинж чанарыг тусган харуулж чадна.

## 14 ДҮГЭЭР ХЭСЭГ

Бахаулла бидэнд ийнхүү айлджээ:

**“Тэнгэрлэг буян хишгийн Өдрийн Од, тэнгэрийн удирдамжийн Эх үүсвэрээс хүмүүний бодит мөн чанарт хайрласан эдгээр чадавхууд нь лаанд нуугдмал орших галын дөл юм уу, дэнлүүнд нуугдмал орших гэрлийн туяа лугаа адил хүмүүнд өөрт нь нуугдмал оршдог болой. Нарны гэрэл тоос тортогт хучигдсан толинд тусч чаддаггүйн адил энэ дэлхийн элдэв дур хүсэлд автан бүрхэгдэх юм бол эдгээр хүч чадлын гэрэл туяа нь харагдахаа больж магад. Лаа ч бай, дэнлүү ч бай өөрөө өөрийгөө асааж чадахгүй, толь ч өөрөө тоос тортогсоо ангижирч чадахгүй билээ. Асаахаас нааш дэнлүү галын дөл**

гаргахгүй, тоос шороог нь арчиж цэвэрлэхээс нааш толь нарны дүр царайг илтгэж, гэрэл гэгээ, гоо жавхааг нь тусган харуулахгүй нь ойлгомжтой бөгөөд тодорхой.”<sup>19</sup>

1. “Нуугдмал орших” гэж юу гэсэн үг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Хүний сүнсэнд нуугдмал орших зарим чадавхуудыг нэрлэнэ үү? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Дэнлүү ямар нөөц чадавхтай вэ? \_\_\_\_\_
4. Толь ямар нөөц чадавхтай вэ? \_\_\_\_\_
5. Дэнлүүнээс гэрэл гаргахын тулд юу хийх ёстой вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
6. Толинд гэрэл тусгахын тулд яах хэрэгтэй вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
7. Толь юм уу дэнлүү өөрсдөө өөрийнхөө нуугдмал чадавхыг нээн илрүүлж чадах уу? \_\_\_\_\_
8. Энэ хоёр жишээг хүний сүнсний нөхцөл байдалтай хэрхэн холбон тайлбарлаж болох вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
9. Хүний сүнсэнд заяагдмал орших нөөц чадавхыг хэн нээн илрүүлж чадах вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 15 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла айлдсан нь:

**“Өнө эртний Оршихуйн тухай мэдлэгийн үүд хаалга хүмүүсийн өмнө хэзээд хаалттай байсан, цаашид ч хаалттай байх болно. Ямар ч хүний ухаан Түүний ариун өргөөнд хүрч үл чадмуй. Гэсэн ч, Тэрээр Өөрийн энэрэл**

нигүүлслийн бэлгэ тэмдэг, Өөрийн хайр халамжийн нотолгоо болгож хүмүүст Өөрийн тэнгэрлэг удирдамжийн Өдрийн Од мичид, Өөрийн тэнгэрлэг эв нэгдлийн Бэлгэ тэмдгүүдийг нээн тодруулж, тэдгээр ариуссан Биесийн тухай мэдлэгийг Өөрийн тухай мэдлэгтэй адил байхаар соёрхжээ. Тэднийг таньсан хэн боловч Бурханыг таньсантай адил. Тэдний дуудлагыг сонсож хүлээн авсан хэн боловч Бурханы Дуу хоолойг сонсож хүлээн авсантай адил буюу. Тэдний Сургаал туурвилын үнэнийг гэрчилсэн хэн боловч Бурханы Өөрийнх нь үнэнийг гэрчилсэн болой. Харин тэднээс ухарч урвасан хэн боловч Бурханаас бас ухран урваж, тэдэнд үл итгэсэн хэн боловч бас Бурханд үл итгэсэн буюу. Тэдний нэг бүр нь энэ дэлхий ертөнцийг тэнгэр диваажинтай холбогч Бурханы Зам бөгөөд газар дэлхий хийгээд диваажинд оршин суугч бүрийн хувьд Бурханы Үнэний Туг далбаа юм. Тэд бол хүмүүсийн дунд Бурханы Тодруулагч нар бөгөөд Бурханы Үнэний нотолгоо, Бурханы алдрын шинж тэмдгүүд юм.”<sup>20</sup>

1. Дээрх эшлэлийг тунгаан бодож дараах асуултуудад хариулна уу:
  - a. Бид Бурханыг шууд танин мэдэх боломжтой юу? \_\_\_\_\_
  - b. Бурханыг тэгвэл бид хэрхэн танин мэдэж болох вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
  - c. Тэнгэрлэг Удирдамжийн Өдрийн Ододын заримаас нэрлэнэ үү: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
  - d. Бурханы Тодруулагчдын дуудлагыг сонссон хүн хэний Дуу хоолойг сонссонтой адил вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
  - e. Бурханы Тодруулагчийн дуудлагыг хүлээн аваагүй бол бид хэнээс нүүр буруулж байна вэ? \_\_\_\_\_
2. Дараах өгүүлбэрүүдийг гүйцээж бичнэ үү:
  - a. Өнө эртний Оршихуйн тухай мэдлэгийн үүд хаалга \_\_\_\_\_ байсан, цаашид ч \_\_\_\_\_ байх болно.
  - b. Ямар ч хүний ухаан \_\_\_\_\_ хүрч үл чадах билээ.
  - c. Өөрийн \_\_\_\_\_ бэлгэ тэмдэг, \_\_\_\_\_ нотолгоо болгож Бурхан Өөрийн Тодруулагч нарыг илгээжээ.
  - d. Бурханы Тодруулагч нарын тухай мэдлэг \_\_\_\_\_ тухай мэдлэгтэй адил.

- e. Тэднийг таньсан хэн боловч \_\_\_\_\_.
- f. Тэдний дуудлагыг сонсож хүлээн авсан хэн боловч \_\_\_\_\_.
- g. Тэдний нэг бүр нь \_\_\_\_\_  
\_\_\_\_\_ Бурханы Зам юм.

3. Дараахын аль нь үнэн бэ?

- \_\_\_\_\_ Бид гагцхүү өөрсдийн хүчин чармайлтын ачаар л оюун санаагаар өсөн хөгжиж чадна.
- \_\_\_\_\_ Бурхан бидэнд оюун ухаан хайрласан тул тэр л бидний өсөлт хөгжилд хангалттай.
- \_\_\_\_\_ Бурханы Тодруулагчийг танин мэдсэнээр бид оюун санаагаар өсөн хөгжих бөгөөд илүү хүчин чармайлт гаргах шаардлагагүй юм.
- \_\_\_\_\_ Бурханы Тодруулагчийг танин мэдэж, Түүний сургаалын дагуу амьдрахын тулд хүчин чармайлт гаргах замаар бид оюун санаагаар өсөн хөгжинө.
- \_\_\_\_\_ Бид Бурханыг шууд танин мэдэж чадна.
- \_\_\_\_\_ Хүн Бурхан шиг болж чадна.
- \_\_\_\_\_ Бурхан бол хүний ойлгон ухаарах чадвараас хавьгүй агуу юм.
- \_\_\_\_\_ Бурханы Тодруулагчийн айлдсан үгийг сонордвол энэ нь Бурханы Дуу хоолойг сонсож буйтай адил юм.

## 16 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла тунхагласан нь:

**“Бурханы Зөнч мэргэд ба Элч нарын доош илгээгдсэний цорын ганц зорилго болбоос хүн төрөлхтнийг Үнэний чиг шулуун Замд оруулах явдал бөлгөө. Тэдний Сургаал туурвилын үндэс суурь нь болж буй зорилго гэвээс хүмүүсийг гэгээрүүлэхэд орших агаад ингэснээр үхэх цаг нь ирэхэд тэд бүрэн ангижрал, дээдийн ариун цагаан зүрх сэтгэлтэйгээр Дээд Тэнгэрийн суудал өөд дүүлэх магад.”<sup>21</sup>**

Бас өөр нэгэн сургаалдаа Тэрээр ийнхүү айлджээ:

**“Хүн болбоос эрхэм дээд Сахиус мөн. Гэвч зүй ёсны боловсрол дутах аваас тэрээр өөрт угаас заяагдмал зүйлээсээ хагацах ажээ. Бурханы амнаас ундарсан нэг үгээр тэрээр амилж, дахин нэг үгийн хүчээр тэрээр өөрийн боловсролын Эх үүсвэрийг таньж, мөн бас өөр нэгэн үгийн хүчээр түүний байр суурь, хувь заяа нь дархлагдан хамгаалагдах буюу. Агуу Бие хэлсэн нь: Хүмүүнийг үнэлж баршгүй эрдэнийн чулуугаар баян уурхай хэмээн үзэгтүн. Зөвхөн боловсрол түүний эрдэнэс баялгийг нээн илрүүлж, хүн төрөлхтөнд ач**

тусыг нь хүртээж чадмуй. Хэрэв аливаа хүмүүн Бурханы ариун Хүсэл эрмэлзлийн тэнгэрээс доош илгээгдсэн Судар бичмэлүүдэд туурвигдсан бүхнийг бясалган тунгааваас, тэдгээрийн зорилго нь бүх хүмүүсийг нэгэн хүмүүн хэмээн тооцоход, улмаар “Хаант Улс болбоос Бурханых” гэсэн тамга хүн бүрийн зүрх сэтгэлд сийлэгдэж, Тэнгэрлэг буян хишиг, гоо жавхлан, энэрэл нигүүлслийн гэрэл гэгээ бүхий л хүн төрөлхтнийг бүрхэн авахад оршино гэдгийг бэлхнээ ойлгон ухаармуй.”<sup>22</sup>

1. Бурханы Зөнч мэргэд ба Элч нар ямар зорилгоор ертөнцөд илгээгдсэн бэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Тэдний Сургаал туурвилын үндэс суурь болсон зорилго нь юу вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. “Сахиус” гэж юу гэсэн үг вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Боловсролоор дутахын үр дагавар юу вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
5. Зүй ёсны боловсрол эзэмших нь ямар үр дүнд хүргэж болох вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
6. Бидний боловсролын Эх үүсвэр юу вэ? \_\_\_\_\_
7. Биднийг ямар хувь тавилан хүлээж байгаа бол? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
8. Боловсролын ачаар илрэх зарим эрдэнэс нь юу вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
9. Ариун Сургаал бичмэл дээр бясалган тунгаавал бид юуг бэлхнээ ойлгон хүлээн зөвшөөрөх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## 17 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү айлджээ:

“Түүнчлэн бие махбодоос салсныхаа дараа сүнс ямар байдалд ордог талаар та Надаас асуулаа. Хэрэв хүний сүнс Бурханы замаар явсан байвал Хайртынхаа алдрын ивээл дор лавтайяа эргэж ирнэ гэдэг үнэнийг чи мэдсүгэй. Бурханы үнэнийг барин тангараглая! Тэр бээр ямар ч үзгээр дүрсэлшгүй, ямар ч хэлээр тайлбарлашгүй тийм агуу байр суурьд хүрэх билээ. Бурханы Үйл хэрэгт үнэнч хэвээр байж, Түүний Замд хөдөлшгүй бат тууштай зогсож чадсан сүнс тэнгэрт халин одсоныхоо дараа Бүхнийг Чадагчийн бүтээсэн бүх ертөнц түүгээр дамжуулан хишиг хүртэх тийм хүч чадлыг агуулах болно.”<sup>23</sup>

1. Дараах өгүүлбэрийг гүйцээж бичнэ үү:

- a. Хэрэв хүний сүнс Бурханы замаар явсан байвал \_\_\_\_\_ лавтайяа эргэж ирнэ.
- b. Тэр бээр \_\_\_\_\_ тийм байр суурьд хүрнэ.
- c. Бурханы \_\_\_\_\_ хэвээр байж, \_\_\_\_\_ хөдөлшгүй бат зогсож чадсан \_\_\_\_\_ дараа \_\_\_\_\_ бүтээсэн бүх ертөнц түүгээр дамжуулан \_\_\_\_\_ агуулах болно.

## 18 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла бидэнд ийнхүү айлджээ:

“Хэн нэгний сүнс бие махбодоосоо салах тэр мөчид дэлхийн хүмүүсийн дэмий төсөөллөөс ангижран ариуссан байвал юутай адис ерөөлтэй билээ. Ийм сүнс нь Бүтээгчийнхээ Хүсэл зоригийн дагуу амьдран хөгжиж, хамгаас дээд Диваажинд нэвтрэн орох болмуй. Тэнгэрийн Дагинас, сүрлэг харшийн оршин суугчид түүнийг тойрон эргэлдэж, Бурханы Зөнч мэргэд ба сонгомол шавь нар түүнтэй ханьсахыг хүснэ. Тэдэнтэй тэрээр чөлөөтэй харилцан хөөрөлдөж, бүх хорвоо ертөнцийн Эзэн тэнгэр Бурханы замналд түүнд тохиосон зүйлсийн талаар дурсан ярих болно.”<sup>24</sup>

“Тэрээр нүгэлтнийг өршөөх ёстой бөгөөд хэзээ ч түүний дорой байдлыг жигшиж үл болно, учир нь өөрийнх нь төгсгөл ямар байхыг хэн ч үл мэднэ. Нүгэлтэн хүн ч үхлийнхээ цагт итгэл сүсгийн мөн чанарт хүрч, мөнхийн цангаагаа тайлж, дээд тэнгэрийн Чуулган өөд нисэн дүүлсэн удаа юутай

**олон билээ! Мөн үнэнч сүсэгтэн хүн тэнгэрт халихын өмнөхөн тамын галд унах хүртлээ өөрчлөгдөж байсан удаа ч юутай олон билээ!”<sup>25</sup>**

1. Бидний сүнс бие махбодоосоо салах тэр мөчид ямар байдалд байх ёстой вэ?  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
2. Дэмий төсөөллийн зарим жишээ юу байж болох вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
3. Дэмий төсөөллөөсөө ангижран ариуссан сүнс үхлийн дараа ямар нөхцөл байдалд амьдарч хөгжих вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Ийм сүнстэй хэн ханьсан нөхөрлөх вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
5. Ийм сүнс нь Бурханы Зөнч мэргэд ба Түүний сонгомол шавь нартай харилцан ярилцах болов уу? \_\_\_\_\_
6. Бид газар дэлхийн амьдрал маань яг хэрхэн, хэдийд дуусахыг урьдчилан мэдэх үү? \_\_\_\_\_
7. Өөрт заяасан мөнхийн амьдралдаа хүрэхийн тулд бид одоо юу хийж болох вэ?  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

## **19 ДҮГЭЭР ХЭСЭГ**

Абдул-Баха ийнхүү тайлбарлажээ. Үүнд:

**“Хүний сүнс материаллаг бүрхүүлээсээ салан одсоны дараа ч өнө мөнхөд амьдрах тул оршин буй бүхий л зүйлийн адил цаашид өсөн хөгжих чадвартай байдаг нь эргэлзээгүй. Тиймээс хорвоогоос хальсан сүнсний цаашдын хөгжил дэвшлийн төлөө, өршөөл хүртэхийн төлөө, эсвэл уг сүнс тэнгэрлэг адис ивээл, буян хишгийг хүртэгч болоосой хэмээн мөргөн залбирч болох билээ. Тийм ч учраас Бахауллагийн туурвисан мөргөл**



уншлага дотор хорвоогоос халигсдын нүгэл гэмийг өршөөн хэлтрүүлэхийг Бурханаас гуйсан байдаг. Түүгээр үл барам, энэ хорвоо дээр хүмүүст Бурхан хэрэгтэйн адил, нөгөө ертөнцөд ч тэдэнд Бурхан хэрэгтэй байна. Хамаг амьтанд ямагт хэрэгцээ шаардлага байдаг бол Бурхан бол энэ хорвоод ч тэр, ирээдүйн ертөнцөд ч тэднээс огтоос хамааралгүй оршдог буй.”<sup>26</sup>

Бид нас нөгчсөн хүмүүсийн сүнсний төлөө яагаад залбиран мөргөх хэрэгтэй вэ?

---

---

---

---

---

---

---

---

## 20 ДУГААР ХЭСЭГ

Абдул-Баха бичихдээ:

“Хүний сүнс энэхүү түр зуурын газрын амьдралаас ангижран Бурханы ертөнц өөд нисэн одоход мэлмийг хаах халхавч нуран унаж, үнэн бодит байдал тодрон гэрэлтэж, өмнө нь үл мэдэгдэж байсан зүйлс тодорхой тунгалаг болж, нуугдмал үнэнүүдийн учиг тайлагдана.

Эхийн хэвлийн ертөнцөд байхдаа хүн чих сонсголгүй, нүд хараагүй, ам хэлгүй байсныг, аль ч мэдрэхүй хөгжөөгүй байсныг бодоод үзэгтүн. Харин тэрхүү харанхуй орчлонгоос гэрэлт энэ ертөнцөд мэндлэнгүүт нүдээрээ харж, чихээрээ сонсож, амаараа ярьж эхэлдэг. Үүний адилаар, энэхүү мөнх бусын гэрээ орхин Бурханы Хаант улс руу зүглэн одмогц тэрээр оюун санаагаар шинээр мэндлэх бөгөөд билгийн мэлмий нь нээгдэж, сүнсний чих сонордон сонсож, урд нь огт мэддэггүй байсан бүхий л зүйлсийн үнэн байдал тодорхой бөгөөд тунгалаг болдог байна”<sup>27</sup> гэжээ.

1. Хоосон зайг нөхөж бичнэ үү.
  - a. Хүний сүнс энэ ертөнцөөс халин одоход,
    - мэлмийг хаах халхавч \_\_\_\_\_,
    - үнэн бодит байдал \_\_\_\_\_,
    - өмнө нь үл мэдэгдэж байсан зүйлс \_\_\_\_\_,

– нуугдмал үнэнүүдийн \_\_\_\_\_.

b. \_\_\_\_\_ ертөнцөд байхдаа бид чих \_\_\_\_\_, нүд \_\_\_\_\_, ам \_\_\_\_\_ байсан.

c. Харин энэ ертөнцөд мэндэлсний дараа бид нүдээрээ \_\_\_\_\_, чихээрээ \_\_\_\_\_, амаараа \_\_\_\_\_ эхэлдэг.

d. Үүний адилаар, Бурханы Хаант улсад очиход бид \_\_\_\_\_ шинээр мэндэлнэ.

e. Тэр үед бидний \_\_\_\_\_ мэлмий \_\_\_\_\_, \_\_\_\_\_ чих маань \_\_\_\_\_, урд нь огт мэддэггүй байсан бүхий л зүйлсийн \_\_\_\_\_ байдал \_\_\_\_\_ бөгөөд \_\_\_\_\_ болдог байна.

2. Дараах өгүүлбэрүүд нь үнэн эсэхийг тодорхойлно уу:

\_\_\_\_\_ Эхийн хэвлийд байхдаа бид энэ ертөнцийн тухай мэддэг байсан.

\_\_\_\_\_ Үхлийн дараах бидний нөхцөл байдлын тухай үнэн бол энэ амьдралд маань нуугдмал байдаг.

\_\_\_\_\_ Үхлийн дараа бидний өмнө ойлголт мэдрэхүйн цоо шинэ хязгаар нээгдэнэ.

\_\_\_\_\_ Нас барсныхаа дараа бид энэ ертөнцөд эргэн ирж дахин мэндэлнэ.

## 21 ДҮГЭЭР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү айлджээ:

**“Хүмүүсийн сүнс бие махбодоосоо салсны дараа бие биеэ таньдаг эсэх талаар асуусан асуултад хариулья. Час Улаан Хөлгөнд нэвтэрч суудлаа олсон Бахан хүмүүсийн сүнс сэтгэл нь хоорондоо ойр дотноор харилцан холбоотой байх агаад амьдрал, хүсэл, зорилго, тэмүүллийн хувьд нэгэн сүнс мэтээр нягт дотно холбоотой байх болно гэдгийг мэдэгтүн. Тэд үнэнхүү ихийг мэдэгч, хурц хараат, ухаарлыг ологсод юм. Бүхнийг мэдэгч, Бүхнээс мэргэн ухаантан Тэрээр ийнхүү захирамжилсан бөлгөө.**

Бурханы Хөлөгт оршин суугч Бахан хүмүүс бүгд нэгд нэгэнгүй бие биеийнхээ нөхцөл байдлыг сайтар мэдэх бөгөөд ойр дотно, эв нөхөрлөлийн холбоогоор холбогдоно. Гэхдээ ийм байдал нь тэдний итгэл бишрэл болон төлөв байдлаас шалтгаална. Адил түвшин, байр суурийг эзлэгсэд бие биеийнхээ чадавх, шинж төрх, амжилт бүтээл ба чанар чансааг бүрэн сайн мэднэ. Харин доод зэрэгт буй сүнснүүд өөрсдөөсөө дээд түвшинд буй сүнснүүдийн байр суурь, алдар гавьяаг хангалттай сайн ойлгон үнэлж үл чадна. Хүн бүр Эзэн тэнгэрээс хувь хишгээ хүртмүй. Бурханд нүүр царайгаа

хандуулж, эцэст нь сэтгэл сүнснийхээ жигүүрийг дэлгэн хамаг бүхний Эзэрхэг Эзэн тэнгэр, Хамгаас хүчтэй, Хамгаас Өршөөнгүй, Хамгаас Энэрэлт Бурхан өөд нисэн дүүлэх хүртлээ Түүний хайрд бат тууштай алхсан тэр хүмүүн адист болой.”<sup>28</sup>

1. Хойд ертөнцөд очоод бид энэ ертөнцөд таньж мэддэг байсан хүмүүсээ таних болов уу? \_\_\_\_\_
2. Дараагийн ертөнцөд сүнснүүдийн хооронд хэр зэрэг ойр дотно холбоо байх вэ?  
\_\_\_\_\_
3. Дараагийн ертөнцөд сүнснүүдийн хооронд байх ялгаа, онцлог чанар нь юунаас шалтгаалах вэ? \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
4. Бурханы буян хишгээс хувь хүртэхгүй үлдэх хүн байх болов уу? \_\_\_\_\_

## 22 ДУГААР ХЭСЭГ

Бахаулла ийнхүү айлджээ:

“Аяа, Миний шадар зарц нар аа! Газар дэлхий дээрх амьдралын тань энэ өдрүүдэд хүссэн санаснаас тань эсрэг зүйлийг Бурхан заяаж илгээсэн бол түүнд гутран гуних хэрэггүй, учир нь баяр цэнгэл, тэнгэрийн жаргалтай өдрүүд та нарыг лавтайяа хүлээж байгаа. Ариун дагшин, оюун санааны гайхамшигтай ертөнцүүд нээгдэж мэлмийг тань баясгах болно. Энэ ба хойд насандаа тэдгээрийн ач тусыг хүртэж, баяр жаргалаас нь хуваалцаж, дундаршгүй гоо жавхлангаас нь хишиг хүртэх хувь тавиланг Бурхан та нарт заяасан юм. Эдгээр ертөнц нэг бүрд та нар очих нь гарцаагүй.”<sup>29</sup>

1. Дараахын аль нь үнэн болохыг тодорхойлон шийднэ үү:  
\_\_\_\_\_ Аливаа юмс бидний хүссэнээр байхгүй бол бид гутран гуних хэрэгтэй.  
\_\_\_\_\_ Муу ч бай, сайн ч бай, ер нь юм бүхнийг Бурхан заяасан.  
\_\_\_\_\_ Баяр цэнгэлтэй өдрүүд биднийг хүлээж байгаа.  
\_\_\_\_\_ Бурханы ариун дагшин, оюун санааны гайхамшигтай ертөнцүүдийг бид үзэх нь гарцаагүй.  
\_\_\_\_\_ Энэ ба хойд насандаа эдгээр ариун дагшин, гайхамшигтай ертөнцүүдийн ач тусыг хүртэх нь бидний хувь тавилан.
2. Бидний хүсэж санаснаас эсрэг зүйл бидэнд тохиолдвол яагаад гуньж гутрах ёсгүй вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

3. Дээрх сургаалдаа Бахаулла бидэнд ямар амлалт өгсөн байна вэ? \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

## 23 ДУГААР ХЭСЭГ

Энэ бүлэгт та хүмүүний амьдралын жинхэнэ утга учрын талаар судалж бясалгасан билээ. Хүний сүнсний мөн чанар, энэ ертөнц дэх бидний амьдралын зорилго, оюун санаалаг зан чанараа хөгжүүлэх шаардлага, мөн баяр цэнгэлээр дүүрэн мөнхийн гайхамшигтай амьдралын тухай бидэнд өгсөн амлалтын талаар та нэлээд зүйлийг олж мэдсэн билээ. Энэхүү номын хоёрдугаар бүлэгт бид өөрсдийн оюун санааны болон оюун ухааны өсөлт хөгжилд анхаарал хандуулахын сацуу нийгмийн хувьсал өөрчлөлтөд хувь нэмрээ оруулах гэсэн хоёр талт зорилгын тухай ярилцсан. Тэгвэл одоо энэ үзэл санааг эргэн сөхөж, сүнсний өсөлт хөгжлийн талаар олж авсан ойлголт дээрээ тулгуурлан уг хоёр талт зорилгын ач холбогдол дээр дахин эргэцүүлэн тунгаах завшаан гарч байна. Доор жагсаасан сэдвээр бүлэг дотроо хэлэлцүүлэг хийвэл таны эргэцүүлэлд тус нэмэр болох болов уу.

1. *Оюун санаалаг зан чанаруудаа хөгжүүлэх*
2. *Бурханы хууль зарлигийг даган биелүүлэх*
3. *Хүн төрөлхтний сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах*
4. *Үйлчлэхүйн замаар урагшлан алхах*

## ТАЙЛБАР ЗҮҮЛТ

1. Абдул-Баха, “*Парист айлдсан айлдварууд*”, дугаар 29.12-13
2. Шоги Эффендигийн нэрийн өмнөөс 1946 оны 4-р сарын 1-нд бичсэн захидлаас
3. Даян Дэлхийн Шударга Ёсны Ордоны өмнөөс 2016 оны 7-р сарын 28-нд бичсэн захидлаас
4. Абдул-Баха, “*Учир нь тайлагдсан зарим асуудал*”, дугаар 66.3
5. Мөн дээрхтэй адил, дугаар 38.5
6. Абдул-Баха, “*Парист айлдсан айлдварууд*”, дугаар 28.16
7. 1937 оны 12-р сарын 31-нд Шоги Эффендигийн нэрийн өмнөөс бичсэн захидлаас
8. “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”, LXXXII, §8
9. Абдул-Баха, “*Учир нь тайлагдсан зарим асуудал*”, дугаар 61.1-2
10. “*Бахауллагийн Сургаалын Дээжис*”, LXXX, §2
11. “*Бахауллагийн Сургаалын Дээжис*” (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), LXXXI, хуу. 130
12. Мөн дээрхийн адил, CLXY, хуу. 274
13. Бахаулла, “*Эрдэнийн нуугдмал үгс*”, Араб хэлнээс, дугаар 32
14. Абдул-Баха, “*The Promulgation of Universal Peace: Talks Delivered by 'Abdu'l-Baha during His Visit to the United States and Canada in 1912*” (Даян дэлхийн энх тайвны тунхаг) (Wilmette, Baha'i Publishing Trust, 1995), хуу. 225-26
15. “*Бахауллагийн Сургаалын Дээжис*” (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), V, хуу. 19
16. Мөн дээрхийн адил, LXXXII, хуу. 133
17. Мөн дээрхийн адил, CLIII, хуу. 261
18. Мөн дээрхийн адил, XXVII, хуу. 62
19. Мөн дээрхийн адил, XXVII, хуу. 63
20. Мөн дээрхийн адил, XXI, хуу. 50
21. Мөн дээрхийн адил, LXXXI, § 1
22. Мөн дээрхийн адил, CXXII, хуу. 210

- 
23. Мөн дээрхийн адил, LXXXII, хуу. 135
  24. Мөн дээрхийн адил, LXXXI, хуу. 131
  25. Мөн дээрхийн адил, CXXV, хуу. 214
  26. Абдул-Баха, “Учир нь тайлагдсан зарим асуудал”, дугаар 62.3
  27. Абдул-Баха, “*Selections from the Writings of ‘Abdu'l-Bahá*”, дугаар 149,3-4
  28. “Бахауллагийн Сургаалын Дээжис” (Монголын Бахайчуудын Үндэсний Оюун Санааны Чуулга, 2015 он), LXXXVI, § 1-2
  29. Мөн дээрхтэй адил, CLIII, § 9